МАНАЙ СОНИНЫ I УЛИРЛЫН НЭМЭЛТ ЗАХИАЛГА ЯВАГДАЖ БАЙНА

MMINFO.

19 дэх жилдээ

# МОНГОЛЫН МЭДЭЭ

Хүн ам 3,124.982.. ҮСХ-ны өчигдрийн мэдээгээр

2017.01.06. Баасан. №003 (4617) | ӨДӨР ТУТМЫН АНХНЫ ЧӨЛӨӨТ ХЭВЛЭЛ | Худалдах үнэ 500 төг

Улаанбаатарт: ӨНӨӨДӨР




**УЛС ТӨР**

ЖОЛОО БАРИХ ЭРХИЙГ НЬ ТАВАН ЖИЛЭЭР ХАСАХ САНАЛ ГАРГАЛАА

**II нүүрт**

**ҮЗЭЛ БОДОЛ**

“АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ХӨГЖЛИЙН ТӨВ” БАЙГУУЛЛАА

**III нүүрт**

ҮЗЭЛ БОДОЛ



# ХЭН ЮУ ХЭЛЭВ

Э.ТУУЛ

*2017 он гарч эхний долоо хоног өнгөрлөө. Энэ өдрүүдэд Ерөнхийлөгчийн сонгуультай холбоотой асуудлууд өрнөж, утааны эсрэг авах арга хэмжээний талаар хэлэлцэж өнжлөө. Түүнчлэн ардчиллын алтан хараацай С.Зоригийн амийг зэрлэгээр хөнөөсөн шүүх хурлын араас зарим нэг асуудал үүссэн нь захиалагчийг олох ажлын хэсэг байгуулж, С.Зориг агсны төрсөн дүү болох УИХ-ын гишүүн асан С.Оюун давж заалдах шатны шүүх хурлыг нээлттэй явуулах хүсэлтийг УИХ-ын Өргөдлийн байнгын хороонд гаргасан ч хүлээж аваагүй юм. Учир нь УИХ шүүн таслах ажиллагаанд хөндлөнгөөс оролцох боломжгүй тул өргөдлийг нь Улсын дээд шүүх болон Шүүхийн ерөнхий зөвлөл рүү хуулийн дагуу шилжүүлэхээр болжээ. Энэ мэтчилэн асуудлууд өнгөрсөн долоо хоногт өрнөсөн бөгөөд энэ хүрээнд хэн хэрхэн байр сууриа илэрхийлснийг “Хэн юу хэлэв” буландаа тоймлон хүргэж байна.*

**Үргэлжлэл нь III нүүрт**

Дугаарын 60 мөр

## Ажлаа хийж чадахгүй байж битгий самраад бай

Э.ТУУЛ

“Миний үеийн эмч нарыг сургуулиа төгсөөд хөдөө, орон нутагт ирж байхад буюу 1966, 1967 онд хөдөө сумдын малчин эхчүүдийн 30-50 хувь нь л эмнэлэгт төрж байсан юм. Ардын хувьсгалын 50 жилийн ой угтсан ажил улс орон даяар хүчтэй өрнөж сумдын эмнэлгүүдийг машин унаатай болгосноор удалгүй эхчүүдийг 100 хувь эмнэлэгт төрүүлж төрөхийн хүндрэл эхийн болон нялхсын эндэгдлийг бууруулж цэвэр өсөлт эрс нэмэгдэж халдварт өвчний гаралт ч буурч, тэмбүү өвчин бараг устах тийшээ хандаж билээ. Эрүүл мэндийн байгууллагын ажил сайн байсан тэр үед сайд нь ч сайд шиг сайдууд ажиллаж байсан даа.

**Үргэлжлэл нь III нүүрт**

ЧУУЛГАНЫ ТАНХИМААС

## Жолоо барих эрхийг нь таван жилээр хасах санал гаргалаа

Ж.ОТГОН

УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаанаар Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэхэд гишүүдийн 77.8 хувь нь дэмжсэн тул анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр холбогдох байнгын хороонд шилжүүллээ. УИХ-аас 2015 онд Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийг шинэчлэн баталж, хэрэгжсэнээр үр дүнгээ өгч байгаа аж. Гэхдээ зарим шийтгэл нь давхардаж байгаагаас зөрчил үүсгэж эхэлсэн тул Засгийн газар дээрх хуулийн төслийг санаачлан өргөн мэдүүлсэн юм. Хэлэлцүүлгийн шатанд УИХ-ын гишүүд согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ жолоо барьж яваа иргэнд ногдуулах хариуцлагыг чангатгах нь зөв. Дээр нь хар тамхи сэтгэцэд нөлөөлөх эм бэлдмэл хэрэглэсэн үедээ авто машин жолоодох байдал түгээмэл болж буй тул үүнд Хууль зүй, дотоод хэргийн яам онцгой анхаарах шаардлагатайг сануулж байсан юм.

**Үргэлжлэл нь IV нүүрт**

ДОТОР НҮҮРТ




8

ДЭЛХИЙ

## НҮБ, МЕКСИК Д.ТРАМПТАЙ ХАМТРАХЫГ ХҮСЭВ

Н.ДАВАА

Энэ онд дэлхий дахинаа болох 10 гол үйл явдлын нэг нь яах аргагүй, НҮБ-ын болон АНУ-ын шинэ тэргүүнүүд тангарагаа өргөж, үүрэгт ажилдаа орох явдал. Тэгвэл 2016 он улирч, 2017 он гарсны эхний өдөр НҮБ-ын шинэ Ерөнхий нарийн бичгийн дарга Антонио Гутерреш тангарагаа өргөсөн. Харин энэ сарын 20-нд үл хөдлөх хөрөнгийн тэрбумтан Доналд Трамп АНУ-ын 45 дахь Ерөнхийлөгчийн тангараг өргөж, Цагаан ордонд нүүж очих билээ. Тэгвэл НҮБ-ын тэргүүн А.Гутерреш тус байгууллагын үүрэг, үйл ажиллагааг хатуухан шүүмжилж буй АНУ-ын дараагийн Ерөнхийлөгчтэй анх удаагаа утсаар ярьжээ. Энэ үеэр ажил хэрэгч байдлаар хэлэлцүүлэг өрнүүлж буйг нь сайшаахын ялдамд цаашдаа үр дүнтэй ажиллаж, АНУ тэргүүтэй холбоотон улс орнуудын НҮБ-д итгэх итгэлийг сайжруулах бодолтой байгаагаа илэрхийлсэн байна. Энэ талаар НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргын хэвлэлийн төлөөлөгч нь олон нийтэд мэдээлжээ. АНУ-ын Нью-Йорк хот дахь төв байрандаа тэрбээр хэвлэлийн хурал зарлаж, хэвлэлийнхэнд хоёр тэргүүний хоорондын ярианы талаар мэдэгдсэн аж. Ингэхдээ “НҮБ, АНУ-ын харилцааны талаар илэн далангүй ярилцсан. Ерөнхий нарийн бичгийн дарга А.Гутерреш Доналд Трамп Ерөнхийлөгчтэй нягт харилцаатай байхаа илэрхийлсэн” гэж тайлбарлажээ. Нөгөөтэйгүүр, Доналд Трампын засаглалын Цагаан ордны хэвлэлийн төлөөлөгч ч мөн хэвлэлийн хурал зарлаж, утсаар ярьсан талаар мэдэгджээ. Тэрбээр “Д.Трамп АНУ-ын татварыг үр дүнтэй, оновчтой зүйлд зарцуулахыг НҮБ-аас хүссэн” хэмээсэн байна. Д.Трамп Ерөнхийлөгчийн тангарагаа өргөвөл АНУ-ын хамгийн их хандив өгч буй НҮБ-ын төсвийг оновчтойгоор ашиглахыг шаардана гэдгээ ч энэ үеэр илэрхийлжээ.

**Үргэлжлэл нь IV нүүрт**




| | ХААН банк Авах | Зарах | | Авах | Зарах |
|---|---|---|---|---|---|
| АМ.ДОЛЛАР | 2484.00 | 2498.00 | ФУНТ | 2993.00 | 3093.00 |
| ЕВРО | 2555.00 | 2622.00 | РУБЛЬ | 39.20 | 42.60 |
| ИЕН | 20.91 | 21.24 | ЮАНЬ | 356.00 | 359.90 |

| | Худалдаа хөгжлийн банк Авах | Зарах | | Авах | Зарах |
|---|---|---|---|---|---|
| АМ.ДОЛЛАР | 2486.00 | 2498.00 | ФУНТ | 3011.00 | 3104.00 |
| ЕВРО | 2561.00 | 2642.00 | РУБЛЬ | 39.59 | 43.70 |
| ИЕН | 20.90 | 21.55 | ЮАНЬ | 357.00 | 360.40 |

*Өчигдрийн 19.00 цагийн байдлаар*

ЧУУЛГАНЫ ТАНХИМААС

# ЖОЛОО БАРИХ ЭРХИЙГ НЬ ТАВАН ЖИЛЭЭР ХАСАХ САНАЛ ГАРГАЛАА


Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

**Үргэлжлэл.**
**Түрүүч нь I нүүрт**

Хэлэлцүүлгийн шатанд Хууль зүй, дотоод хэргийн сайд С.Бямбацогт “Хар тамхи сэтгэцэд нөлөөлөх эм хэрэглэж байгаа үйлдлүүдтэй хуулийн байгууллага бололцоогоороо ажил зохион байгуулж байна. Гол нь энэ төрлийн бодисыг хэрэглэсэн хүнийг нь илрүүлсэн ч газар дээр нь баталгаажуулах тоног төхөөрөмж дутмаг байгаа тул цаашдаа УИХ-аас санхүүгийн дэмжлэг хүснэ. Архи, согтууруулах ундаа хэрэглэсэн жолооч нарыг автомашин жолоодож явах үед замын цагдаа зогсоогоод согтолтын хэмжээ зэргийг нь үлээлгээд согтолтыг тогтоодог. Тавантолгойн замд нүүрсний тээвэр хийдэг жолооч нар унтахгүйн тулд сэтгэцэд нөлөөлөх эм хэрэглэдэг, үүнээсээ болж осол аваар гардаг гэх асуудлыг Өмнөговь аймгаас сонгогдсон УИХ-ын гишүүд тавьсан тул нүүрс тэвээрлэж байгаа хэсэгт хяналт тавих зорилгоор замын цагдаагийн хэсэг байгуулж ажиллахаар ажиллаж байна” гэв. Харин УИХ-ын гишүүн Г.Зандашатар “Согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодвол манайд зургаан сараар жолоо барих эрхийг хасдаг. Хятад болоод бусад оронд энэ тохиолдолд торгохоос гадна баривчлах шийтгэл давхар ногдуулдаг. Тэр дундаа хар тамхи хэрэглэсэн иргэдийн хувьд тест өгөхгүй, эрхээ эдэлнэ гэж гүрийх зэрэг асуудал гардаг тухай яригдаад байна. Давхар шийтгэл ногдуулахгүй байх тал дээр олон улсын жишгээрээ ямар байдаг вэ” гэдгийг тодруулсан юм. Ажлын хэсгийн тайбарлаж буйгаар “Хуулийн төсөлд үндсэн шийтгэлийг давхардуулах ёсгүй гэдэг утгаар нь өөрчлөлт оруулж байгаа юм. Торгох шийтгэлийг баривчлах шийтгэлтэй хамтатган хэрэглэж болохоор байгаа” гэв. Харин УИХ-ын гишүүн Н.Оюундарь “Зөрчлийг давтан үйлдсэн бол 30 хоногийн хугацаатай баривчлах, жолоо барих эрхийг нь гурван жилийн хугацаагаар хасах гэж заажээ. Үүний жолоо барих эрхийг нь таван жилээр хасах болгон сунгах нь зөв болов уу. Согтуугаар автомашин жолоодох нь эрсдэлтэй учраас хариуцлагыг өндөржүүлэх шаардлагатай гэж үзэж байна” хэмээсэн юм.

## Хууль тогтоомжийг 2020 он хүртэл боловсронгуй болгох хуулийн төслийг дэмжлээ

УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаанаар өөр нэг хэлэлцсэн асуудал нь “Монгол Улсын хууль тогтоомжийг 2020 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл батлах тухай” УИХ-ын тогтоолын төслийг эцсийн хэлэлцүүлэгт шилжүүллээ. Засгийн газраас өргөн мэдүүлсэн энэхүү үндсэн чиглэлийн төсөлд 260 хуулийн төсөл, үүнээс 2016 онд 31, 2017 онд 131, 2018 онд71, 2019 онд 24, 2020 онд гурав, төсөл боловсруулж өргөн мэдүүлэхээр заасан байна. Мөн Үндсэн чиглэлийн төсөлд тусгагдсан 260 хуулийн төслийг хууль санаачлагчаар нь авч үзвэл, Засгийн газар 239, УИХ-ын гишүүд 17, Монгол Улсын Ерөнхийлөгч дөрөв, хуулийн төсөл тус тус санаачлахаар, УИХ-ын тогтоолын төслийн хувьд Засгийн газар-12, УИХ-ын гишүүд гурав, Монгол Улсын Ерөнхийлөгч нэг тогтоолын төсөл тус, тус санаачлахаар тогтоолын төсөлд тусгажээ. Үндсэн чиглэлийн төсөлд тусгагдсан 260 хуулийн төслийн 75 нь анхдагч хуулийн төсөл, 85 нь шинэчилсэн найруулга, 99 нь хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, нэг нь хууль хүчингүй болгох тухай хуулийн төсөл юм. Монгол Улсын хууль тогтоомжийг 2020 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл батлагдсанаар Засгийн газраас 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан зорилтыг биелүүлэх,хуульсанаачлагчдаас санаачлах хууль тогтоомжийн төслүүд давхардалгүй, тодорхой цаг хугацаанд төлөвлөгдөн, өөр хоорондоо уялдаа холбоотой боловсруулагдах боломжтой болох юм. Хэлэлцүүлгийн шатанд: УИХ-ын гишүүн Л.Болд “Энэ баримт бичигт дахин боловсруулалт орох шаардлагатайгаар батлагдах болж байгаа юм биш үү. Яагаад гэвэл энэ төсөлд 2016 онд батлах маш олон хууль багтсан байна. УИХ-аар батлагдаад хэрэгжиж байгаа хуулиудыг хасахгүй юм уу. Дээр нь УИХ-ын гишүүдийн өргөн мэдүүлсэн Гадаад харилцааны тухай хуулийн төсөл УИХ-аар хэлэлцэгдэж байгаа. Гэтэл Засгийн газар өргөн барина гэж байна. Эдгээр зөрчлүүдээ арилгахын тулд хоёрдугаар хэлэлцүүлэг дээр ажлын хэсэг гаргах ёстой.Төлөвлөгөөны 251, 252, 253-д Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хууль, УИХ-ын сонгуулийн тухай хууль, орон нутгийн сонгуулийн тухай хуулийг О.Баасанхүү гишүүн бид хоёр дээр тавьчихаж. Гэтэл одоо Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийг хэлэлцээд явж байна” гэлээ. Үүний хариуд Хууль зүй, дотоод хэргийн сайд С.Бямбацогт “Хууль зүйн байнгын хорооны хуралдаанаар тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг хийх үед өнгөрсөн онд УИХ-аар батлагдсан хуулиудыг үндсэн чиглэлдээ тусгах шаардлагагүй гэж үзээд хассан. Сонгуулийн хуулийг өргөн барина гэж та саналаа өгсөн учраас үндсэн чиглэлд тусгаж өгсөн. Үндсэн чиглэд тусгаад өгөхөөр өнөөдөр та өөрөө, өөртэйгээ зөрчилдсөн юм ярих юм. “О.Баасанхүү бид хоёр Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хууль, УИХ-ын сонгуулийн тухай хууль, орон нутгийн сонгуулийн тухай хуулийг өргөн барих боллоо, та нараад хууль санаачлуулах боллоо” гээд байх юм” гэв.

> ...Сонгуулийн хуулийг өргөн барина гэж та саналаа өгсөн учраас үндсэн чиглэлд тусгаж өгсөн. Үндсэн чиглэд тусгаад өгөхөөр өнөөдөр та өөрөө, өөртэйгээ зөрчилдсөн юм ярих юм...

Тэгвэл УИХ-ын гишүүн Н.Энхболд “УИХ, орон нутгийн сонгуулийн тухай хуулийн төслийг өргөн барих учраас жагсаалтад оруулахаас аргагүй. Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн төслийг өнөөдөр ярина. Ардчилсан намын бүлгээс ажлын хэсэгт 3 хүн оруулъя гээд нэр ирүүлсэн. Үүнд Л.Болд гишүүний нэр орсон. Идэвхитэй оролцоод яваарай” хэмээсэн юм.

Ийнхүү Улсын Их Хурлын гишүүд хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан асуулт асууж тодруулсны дараа байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй 56 саналын томьёоллоор санал хурааж шийдвэрлэн хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүллээ.

Дугаар шилжих мөчид УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаанаар Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн төслийг хэлэлцэж байв.

MMINFO.

МОНГОЛЫН МЭДЭЭ

19 дэх жилдээ

Ерөнхий эрхлэгч: С.ГАНТОГОО

Орлогч эрхлэгч Ч.ЧУЛУУНЦЭЦЭГ 99189158

Хариуцлагатай нарийн бичгийн дарга: Э.ЭНХЦЭЦЭГ 90873012

Ахлах редактор: Б.ӨНӨРТОГТОХ 88006842

Шуурхай мэдээлэл, эрэн сурвалжлах алба Н.ПУНЦАГБОЛД 88096454

Улс төр, гадаад мэдээлэл, эдийн засгийн алба: Б.ӨНӨРТОГТОХ 88006842

Гэрэл зургийн алба: Г.АРГУУЖИН 96017873

Компьютерийн алба: Б.ГАНЗОРИГ 99998796

Маркетинг, зар сурталчилгааны алба: Н.АЛТАНЦЭЦЭГ 99173710

Захиалга, борлуулалтын алба: М.ДАВААДУЛАМ 99042510

Э.САЙНЗАЯА 99197866

Дугаарыг эрхэлсэн Н.ПУНЦАГБОЛД

Улсын бүртгэлийн дугаар: 907300528
Индекс: 100757

**Редакцийн хаяг:**
**Улаанбаатар хот. Сүхбаатар дүүрэг. Чөлөөт хэвлэл сан /Хэвлэлийн хүрээлэн/.**
**2 давхар. 209, 211 тоот**

**Харилцах утас, факс:**
**976-70113551**

**“Монголын мэдээ” сонины редакцид эхийг бэлтгэж, “Чөлөөт хэвлэл сан”-ийн хэвлэх үйлдвэрт хэвлэв.**

## Н.Учрал: ХААИС-ийн олон бүтээлүүдээс бизнесийн боломж харагдаж байна

УИХ-ын гишүүн Н.Учрал УИХ дахь Инновацийн лобби бүлгийг тэргүүлдэг. Аль салбарт шинэчлэл хэрэгтэй тэнд хүрч ажиллах зорилготой тус бүлэг өчигдөр Хөдөө, аж ахуйн их сургуульд ажилласан байна. УИХ-ын гишүүн Н.Учралын хувьд боловсрол болоод инновацийн салбараа хөгжүүлж байж Монгол улс хөгжинө гэж үздэг. Тийм ч учраас оюуны салбараа хөгжүүлж ажиллахыг уриалдаг УИХ дахь цөөн гишүүний нэг юм. Инновацийн салбарыг дэмжих лобби бүлгийнхэн Хөдөө, аж ахуйн их сургуульд ажиллахдаа инженер техникийн сургууль, Ургамал хамгааллын эрдэм шинжилгээний хүрээлэн, Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лаборатори, ХААИС-ийн инноваци бизнес хөгжлийн төвийн харъяа Агропаркын үйл ажиллагаатай танилцан, ХАА-н шинжлэх ухаан, үйлдвэрлэлийн холбоог бэхжүүлэх боломж, тулгамдаж буй асуудлаар эрдэмтэн, судлаачидтай санал солилцсон юм. Мөн эрдэмтэн, судлаачидтай хамтын ажиллагааг сайжруулах, шийдвэрлэх шаардлагатай асуудлаар олон талын оролцоог хангасан уулзалт хийсэн. Энэ талаар УИХ-ын гишүүн Н.Учрал "Өдгөө ХААИС нь Монгол орны дахин давтагдашгүй ургамал болон амьтны нөөц, хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүн, түүхий эдийн биохими, хими биологийн онцлог шинж, тэдгээрийн чанар, аюулгүй байдлын үзүүлэлтийг судлан тогтоох чадамжтай юм байна. Түүнчлэн амьд бие организмийг молекулын төвшинд нарийвчлан судлах, шилмэл генитэй ургамал, амьтан гарган авах улмаар өндөр ашиг шимтэй малын хөврөл үржүүлэн суулгах эс, эдийн өсгөвөр хийх, гүн хөлдөөсөн үрийн сан бүрдүүлэх зэрэг судалгаа, хөгжлийн ажлыг Олон улсын төвшинд гүйцэтгэх боломж бүрдсэн байна. Хамгийн гол нь эдгээр олон бүтээлүүдээс бизнесийн боломж харагдаж байна. Инновацийн үйл ажиллагааг дэмжих нь улс орны ирээдүйн хөгжлийн ахицыг тодорхойлох нь дамжиггүй" гэлээ. Энэ үеэр УИХ-ын гишүүн Д.Гантулга болон ажлын хэсгийн бусад гишүүд хамт байлцсан юм. ХААИС-ийн талаас сургуулийн удирдлагууд болон тус сургууль дээр байрладаг Инноваци бизнес хөгжлийн төвийн захирал Б.Мөнхбат, инновацийн бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг гарааны компаниудын захирлууд, хөдөө аж ахуйн салбарын тэргүүлэх судлаачид оролцсон. Тус сургуулийн захирал Т.Хэрүүгаагийн мэдээлж буйгаар тус сургууль өнгөрсөн хугацаанд 500 инновацийн бүтээгдэхүүн гаргасан байна. Мөн инновацийн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэлд нэвтрүүлэх туршилт, судалгаа хийхэд шаардлагатай лаборатори нэмж байгуулан, инновацийн бүтээгдэхүүний судалгааг дэмжих сан бий болгож, эрдэмтэн судлаач, багш нарынхаа хийсэн судалгааны бүтээлд урамшуулал олгодог болжээ. Дараа нь Инноваци бизнес хөгжил төвийн захирал Б.Мөнхбат танилцуулга хийж, төвийнхөө үйл ажиллагааны талаар мэдээлэл өгсөн. Ажлын хэсгийн ахлагч Н.Учрал “Маш тодорхой мэдээлэл өгсөн эрдэмтэн багш, судлаачдадаа юуны өмнө талархал илэрхийлье. Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооноос гарсан ажлын хэсэг маш өргөн бүрэлдэхүүнтэй. Ажлын хэсэг төлөвлөгөөний дагуу ажлаа эхэлж, энд ажиллаж байна. Ажлын хэсгээс гадна УИХ-д инновацийн үйл ажиллагааг дэмжих, манлайлах лобби бүлэг байгуулагдсан. Уг бүлэгт бүх байнгын хорооноос гишүүд орсон бөгөөд ажлын хэсэг энэ бүлэгтэйгээ хамтарч ажиллаж байна. Ажлын хэсэг Инновацийн тухай хууль гарсны дагуу үйл ажиллагаа явуулж, бизнес эрхэлж байгаа хүмүүс, эрдэмтэн судлаачдынхаа үгийг сонсож, цаашид юу хийж хэрэгжүүлэх шаардлагатай талаар Байнгын хороонд дүгнэлтээ танилцуулна. Дараа дараагийн ажил нь байнгын хорооноос Засгийн газарт чиглэл өгөх, мөн шаардлагатай бол хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, дүрэм журам гаргах, бусад байдлаар дэмжлэг үзүүлэх зэрэг өргөн хүрээнд өрнөнө. Та бүгдийн ярианаас ХААИС-ийг түшиглэсэн 14 гарааны компани байгуулагдаад үйл ажиллагаа явуулж байгааг сонсоход таатай байна.

Мөн Инноваци бизнес хөгжлийн төв ажилладаг нь маш чухал. Ректорын илтгэлд гарснаар сургууль санхүүжилтийн орлогоо дан ганц сургалтын төлбөрөөр бүрдүүлэх бус эрдэм шинжилгээ, судалгааны бүтээлийн орлогоос 50 хүртэл хувийг бүрдүүлэхээр ажиллаж байгаа нь цаг үеэ олсон дэвшил юм. Та бүхнээс амжилттай яваа ажлаас гадна тулгарч буй бэрхшээл, саад зэрэг бодит байдлаа ил тод, нээлттэй танилцуулаарай гэж хүсч байна, бид ч шийдүүлэхийн төлөө ажиллана” хэмээлээ. Эцэст нь Инновацийн бизнес хөгжлийн төвийн барьж буй дөрвөн давхар барилгын ажилтай танилцсан. Тус төв ХААИС дээр нэг жижиг өрөөнд үйл ажиллагаа явуулж буй бөгөөд цаашид тусдаа байртай болсноор гарааны компаниудаа уг байрандаа оруулж, үйл ажиллагаагаа улам хөгжүүлэх зорилго тавьж буй юм байна. Байрыг ашиглалтад оруулахад шаардагдаж буй 200 гаруй сая төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлэхэд УИХ-аас тэд дэмжлэг хүслээ.

## Улсын комисс шинэ нисэх буудлын хугацааг сунгахаар боллоо

“Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны шинэ буудал барих төслийн зээлийн хөрөнгөөр баригдсан барилга байгууламж, тоног төхөөрөмжийг ашиглалтад хүлээн авахаар ажиллаж буй Улсын комисс ээлжит хурлаа хийлээ. Улсын комиссын бүрэлдэхүүн нийт 11 хэсэг болон ажиллаж байгаа бөгөөд энэ удаагийн хуралдаанаар ажлын хэсгийн ахлагч нарын өнгөрсөн хугацаанд хийгдээд буй хяналт шалгалтын ажлын тайлан, санал дүгнэлтийг хэлэлцлээ. Ажлын хэсгийн ахлагч нарын мэдээлж буйгаар хяналт шалгалтыг сайтар хийх, гарч буй зөрчил дутагдлуудыг арилгуулахад хугацаа шаарлагатай тул хурлаас Улсын комиссын ажиллах хугацааг сунгахаар шийдвэрлэлээ. Харин хэдий хугацаагаар сунгахыг ажлын хэсгүүдээс санал авч тогтоох юм байна. Хуралдааны төгсгөлд Улсын комиссын дарга Б.Цогтгэрэл комиссын бүрэлдэхүүнд орсон хүмүүс цаг нарийн баримтлахыг хатуу анхааруулсан. Тэрбээр “Улсын комиссын бүрэлдэхүүнд багтсан зарим хүмүүс хоцрох, ирэхгүй байх тохиолдол гарч байна. 650 сая ам.долларын бүтээн байгуулалт, хөрөнгийг хүлээж авахын тулд комиссын гишүүд маш хянамгай, чин шударга ажиллаж, сайтар шалгах ёстой. Комиссын бүрэлдэхүүнд орж ажиллаж буй хүмүүс хариуцлага алдвал хуулийн хариуцлага хүлээнэ шүү. Цаг бага үлдсэн тул хариуцлагатай ажиллах шаардлагатай” хэмээн анхааруулсан юм. Улсын комиссын бүрэлдэхүүнд орж ажиллаж буй хүмүүс комисс ажиллах хугацаанд ажлаасаа чөлөөлөгдөж байгаа бөгөөд комиссын гишүүдийн цаг бүртгэлийг хөтөлж ажиллахыг Улаанбаатар хотын Олон улсын шинэ нисэх буудлын Ашиглалтын өмнөх захиргааны албаны дарга Д.Мөнхцогд үүрэг болголоо. ЗТХ-ийн сайдын тушаалаар БХБЯ, АМГТГ, МХЕГ, “МИАТ” ТӨХК зэрэг байгууллагын 27 хүнийг Улсын комиссын бүрэлдэхүүнд нэмж ажиллуулж байна.



# ҮЗЭЛ БОДОЛ

ҮЗЭЛ БОДОЛ

# ХЭН ЮУ ХЭЛЭВ

**Үргэлжлэл.**
**Түрүүч нь I нүүрт**

## Ч.Содномцэрэн: Хууль батлагдсаны дараа сонгуулиа товлоно

*/СЕХ-ны дарга/*

Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн төслийн талаар СЕХ-ны дарга Ч.Содномцэрэн "Хуулийн дагуу сонгуультай холбоотой саналыг СЕХ-ноос УИХ-д хүргүүлнэ гэсэн заалттай. Мөн УИХ-ын намрын чуулганы хэлэлцэх асуудлын дараалалд сонгуулийн тухай хуулинд нэмэлт өөрчлөлт оруулахаар тусгасан. Энэ хүрээнд Н.Энхболд нарын гишүүд хамтарч одоогийн хуулийн төслийг өргөн барьсан. Тиймээс хуулийн төсөлтэй холбогдуулж СЕХ саналаа хүргүүлсэн юм. Хуульд зарчмын чанартай томоохон өөрчлөлт ороогүй. Том өөрчлөлт гэвэл нэгдсэн хуулиасаа Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийг салгаж, бие даасан хууль болгож байгаагаараа онцлогтой. Хоёрдугаарт, 2015 онд нэгдсэн хуулийн хэлэлцүүлэг явж байх үед СЕХ дэмжих боломжгүй гэдгээ илэрхийлж, тухайн үеийн ажлын хэсэгт хүргүүлж байсан. Гэвч бидний саналыг хүлээн авалгүй хуулиа баталсан. Нэгдсэн хуулиар сонгуулийг зохион байгуулснаар зарим заалтууд дээр будилах явдал өнгөрсөн сонгуулиар гарч байсан. Тиймээс СЕХ өнгөрсөн сонгуулийн явцад будилж төөрөлдсөн асуудлууд дээр арга зүйн зөвлөгөө өгч ажилласан. Одоо тусдаа хууль гарахаар төөрч будилах явдал гарахгүй. Түүнчлэн нэгдсэн хуульд орхигдуулсан зүйл заалт цөөнгүй байсан. Тодруулбал, сонгууль өгөх эрх бүхий иргэдийг орхигдуулсан тал бий. Энэхүү заалтыг хуулийн төсөлд нэмж оруулсан. Батлан хамгаалах яамны шугамаар алба хааж байгаа алба хаагчдыг бүртгэхээр хуульчилсан бол хилийн цэргийнхнийг бүртгэх эсэх нь тодорхойгүй байсан. Гуравдугаарт, нэгдсэн хуульд товлон зарлах, санал авах өдрийг тогтоохын тулд хоёр тусдаа хийж өгсөн байсан. Өөрөөр хэлбэл, УИХ хоёр удаа хуралдаж, нэг удаад нь товоо тогтоодог. Дахин хуралдаж санал авах өдрөө тогтоодог байсныг өөрчилж, нэг тогтоолоор дээрх хоёр асуудлыг шийддэг байхаар өөрчлөлт оруууллаа.

## О.Баасанхүү: Хэнийг ч хамаагүй нэр дэвшүүлье л дээ

*/УИХ-ын гишүүн/*

-Ерөнхийлөгчийн сонгуулийн хуулийн хэлэлцүүлгийг орхиж гарсан О.Баасанхүү гишүүн "Юуны түрүүнд Үндсэн хуулиа харах ёстой. 45 нас хүрсэн, Монгол Улсын уугуул иргэн Ерөнхийлөгчид нэр дэвших эрхтэй. Хүнийг нам, нийгмийн гарлаар нь гадуурхахгүй гээд Үндсэн хуульд заачихсан шүү дээ. Өөрөөр хэлбэл, Ерөнхийлөгчид нэр дэвшигч нь аль нэг намын гишүүн байхыг Үндсэн хуулиар үүрэгжүүлээгүй. О.Дашбалбар агсан бие даан нэр дэвшин, УИХ-ын гишүүн болоод Монголын уламжлалын нэгдсэн намд орж, Ж.Гомбожав гуайг тус намаас Ерөнхийлөгчид нэр дэвшүүлж байсан. Улмаар УИХ-д суудал бүхий нам гэдэг нь сонгуульд оролцсон, гишүүн нь сонгогдсон намыг хэлэх талаар тайлбар гарсан. Энэ тайлбараар бол одоогийн нөхцөлд гурван нам л нэр дэвшүүлнэ. Гэтэл уг төсөлд нэр дэвшигч нь заавал аль нэг намын гишүүн байх ёстой гэж тусгасан. Заавал өөрийн намын хүнийг нэр дэвшүүлнэ, өөр намын хүнийг болохгүй гээд хатуу заачихсан. Энэ нь Үндсэн хууль болон сонгуулийн тогтолцоог бүхэлд нь зарчмын алдаатай болгон харуулахаар байгаа юм. Үүгээрээ Монгол Улсын иргэний сонгох, сонгогдох эрхийн бололцоог хязгаарлаад байна. Ерөнхийлөгч бол намаас үл хамааран бүх ард түмний эв нэгдлийг илэрхийлэгч, Төрийн тэргүүн. Тийм ч учраас Ерөнхийлөгчийн сонгуулиар Монгол Улс нэг тойрог болдог. Парламентад суудал бүхий нам зөвхөн нэр дэвигүүлэх эрхийг л эдэлдэг. Тодорхой хэлбэл, гурван сая хүнээс гурав нь л Ерөнхийлөгчийн төлөө өрсөлдөнө. Харин сонгох эрх нь ард түмний гарт байгаа. Сонгогдсон хүн нь хүссэн ч, эс хүссэн ч намын гишүүнээсээ сайн дураар татгалздаг шүү дээ. Ардын нам л хүнээ дэвшүүлье гэж байна шүү дээ. Парламентад суудалтай гурван намын төлөөлөл сууж ярилцах боломж өгсөнгүй. Миний эгдүүцээд байгаа шалтгаан ердөө л энэ. АН, МАН чинь бөх, дуучин нэр дэвшүүлж болдог нам шүү дээ. 45 нас хүрсэн, Монгол Улсын уугуул иргэн л бол хэнийг ч хамаагүй нэр дэвшүүлье л дээ. "УИХ-д суудал бүхий намаас 45 нас хүрсэн, Монгол Улсын уугуул иргэнийг нэр дэвшүүлэх эрхтэй" гэсэн ганцхан өгүүлбэр оруулахыг л хүсээд байгаа юм. Тэр нь хэн ч байсан яадаг юм бэ. Яагаад гэвэл Монголын ард түмэн тэнэг биш. Зарим буруу зүйлийг засах ёстой. Жишээ нь, Ерөнхийлөгчид нэр дэвшиж байгаа хүн 18 хоногт сурталчилгаа хийж болохгүй. Монгол Улс даяар танигдсан хүн юм чинь заавал олон хоног сурталчлах шаардлагагүй гэж яриад байгаа юм. Тэр хүн өөрийнхөө тухай биш, ирэх дөрвөн жил хийх ажлаа ярих гээд байна шүү дээ. Түүнээс биш, олонд хамгийн сайн танигдсан хүн гэвэл хошин урлагийнхан л байна биз дээ" хэмээжээ.

## Д.Оюунхорол: Утаанаас салах, тав тухтай амьдрах эцсийн шийдэл бол ард иргэдээ орон сууцжуулах явдал

*/УИХ-ын гишүүн, БОАЖ-ын сайд/*

Тэрбээр утааны эсрэг авах арга хэмжээ буюу гэр хорооллын цахилгааны шөнийн тарифыг тэглэсэн талаар хэвлэлд өгсөн ярилцлагадаа "2017 оны нэгдүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн гэр хорооллын айл өрхийн шөнийн цагт ахуйн зориулалтаар хэрэглэсэн цахилгааны үнийг тэглэлээ. Хөнгөлөлтөд хамрагдах гэр хорооллын өрхүүд оройн 21:00 цагаас өглөөний 06:00 цаг хүртэл цахилгааныг үнэ төлбөргүй ашиглана. Цахилгаан эрчим хүчний өргүй байх, стандартын шаардлага хангасан баталгаажсан шөнийн тарифт электрон тоолууртай байх зэрэг зохицуулалттай. 146 мянган хэрэглэгч хамрагдах боломжтой. Гэр хорооллын айл өрхүүд маань энэ боломжоо зөв, бүрэн ашиглаж чадвал маш сайн үр дүн гарна. Тухайлбал, иргэдээс, айл өрхөөс хамаарах зүйл маш их. Жишээ нь, гэр хорооллын нийт хэрэглэгчийн 75 хувь нь тарифт тоолууртай байна. Үлдсэн хувь нь тарифт тоолууртай болох шаардлагатай. Мөн өнөөдөр стандарт хангасан халаагуууртай айл хэд байна. Халаагуур авах боломжтой нь хэд байна. Энэ хөнгөлөлт маань нөгөө талдаа стандарт бус цахилгаан халаагуур хямд авах, борлуулах боломж нээчих вий, галын аюул дагуулах вий гэдэг болгоомжлол байна. Цахилгаан халаагуур болон гэр рүүгээ оруулж байгаа цахилгааны утасны стандартыг нарийн мөрдөхийг хүсч байна. Төр засаг ийм зоримог шийдвэр гаргаж байхад иргэд өөрсдөөс хамаарах зүйлийг бүгдийг хийж чадвал үр дүн шууд харагдана. Мөн авто тээврийн хэрэгслээс үүдэлтэй агаарын бохирдлыг бууруулах хүрээнд Евро 4, 5 стандартад нийцсэн сайн чанарын шатахууны импорт, хэрэглээг дэмжих, автомашины улсын үзлэгийн оношлогооны чанарыг сайжруулах, 7-оос дээш насжилттай автомашины импортыг үе шаттай хязгаарлах арга хэмжээ авна. Нийтийн тээврийн үйлчилгээг боловсронгуй, хүртээмжтэй болгож түгжрэлийг сааруулахын зэрэгцээ автобусыг хийн түлшинд үе шаттай шилжүүлэх зорилт тавин ажиллаж байна. Монголд бүх үйл ажиллагааг зогсоогоод гэртээ суувал гэрээ ихээр галлаж, утаа улам нэмэгдэнэ. Бээжингийн агаарын бохидлын гол үүсвэр нь үйлдвэрийн утаа, манайх бол гэрийн яндангийн утаа шүү дээ. Түүхий нүүрсээ юугаар орлуулах вэ гэдгээ тууштай шийдэж байж л хориглож чадна. Цаашдаа түүхий нүүрсний хэрэглээг аажмаар багасгаж бүр хэрэглээнээс гаргах л хэрэгтэй. Ер нь утаанаас салах, тав тухтай амьдрах эцсийн шийдэл бол ард иргэдээ орон сууцжуулах шүү дээ. Гэр хорооллын дахин төлөвлөлт, орон сууцжуулах хөтөлбөрийг зайлшгүй хэрэгжүүлэх ёстой. Хятадын 50 сая юаний буцалтгүй тусламжийг энэ хөтөлбөрт зарцуулахаар шийдвэрлэсэн. Хамгийн хүчтэй Засгийн газар ч агаарын бохирдлыг дангаараа шийдвэрлэж чадахгүй. Иргэдийн ухамсар, оролцоо, хариуцлага чухал гэдгийг онцлон хэлмээр байна.

## Л.Жавзмаа: Хүү минь "Үнэн юм гэж байдаггүй юм байна" гэж хэлсэн

*/Шүүгдэгч Б.Содномдаржаагийн ээж/*

Ардчиллын алтан хараацай С.Зоригийн амийг зэрлэгээр хөнөөсөн хэргийг шүүх хурал 18 жилийн дараа болж, шүүгдэгч Ц.Амгаланбаатар, Б.Содномдаржаа нарт 25 жил, Т.Чимгээд 24 жилийн хорих ял тус тус оноосон. Тэгвэл хүүг нь хилсээр хүн амины хэрэгт буруутган ялласан хэмээн үзэж буй Б.Содномдаржаагийн ээж Л.Жавзмаа "Шүүхээс гаргасан шийдвэртэй огт санал нийлэхгүй байгаа. Мэдээж хэрэг хийгээгүй байхад эсэргүүцэх нь аргагүй шүү дээ. Бид шүүхийг үнэн зөвөөр ажилладаг гэж найдаж байсан. Гэтэл улс төрийнхөө хэргийг гэмгүй хүмүүсийг хийсэн болгож гүтгээд л хэрэг хийсэн болгочихож байна. Шүүх хурлын үеэр ял өгөх хүртэл хүн амьтнаас үнэн зөвийг тодруулж асуулгүйгээр шууд тогтоолоо уншаад яллачихаж байгаа юм. Эд нарын зохион байгуулсан аймшигтай жүжиг гэж харж байна. Хамгийн гол нь С.Зоригийг хөнөөсөн хэргийн гэрчүүдийн ярьж байсан зүйл одоо огт өөр болчихоод байгаа юм. Тэр үед 35-40 насны тийм тийм хүн алсан гээд ам зураг хүртэл гарсан байдаг. Гэтэл 16-тай 21-тэй хүүхдүүд очоод хүн алчихдаг гэж юу байх вэ дээ. Ямар ч хүн эрүүл ухаанаар бодоод олохгүй. Ийм том хэрэг гараад, өдий хүртэл 18 жил алуурчнаа олоогүй байж байгаад гэмгүй нэгнийг хэлмэгдүүлээд орхих гэж байна шүү дээ. Шүүх хурлын дараа элдэв тайлбар хэлээд, хүүтэй минь уулзуулаагүй. Харин энэ сарын 04-нд хорих ангиас зөвшөөрөл авч, хүүгийнхээ барааг харлаа. Сэтгэл санаагаар унасан харагдана билээ. Миний хүүг шүүх хурал дээр үг ч хэлүүлээгүй. Шууд 25 жилийн ял өгчихөөр хүн яах вэ. Хүү минь надад өнөөдөр уйлж байгаад нэг л үг хэллээ. Үнэн юм гэж байдаггүй юм байна гэж. Хэргийн тухай ярьж байгаад, нэг удаа алх цохиод, онц хүнд гэмт хэрэгтэн гээд зарлачихсан. Хүү минь гэм хийгээгүй учраас өрийгөө ялтан болчихно гэж санаагүй. Би гэм хийгээгүй байхад гэж итгэж байсан нь тэр. Гэм хийгээгүй хүн гэмгүй гэдгийг минь батална гэж хүлээж суусан. Өнөөдрийг хүртэл тэвчсэн. Хуралдаанаар гэмт хэргийн тухай уншиж байснаа үгийнх нь үнэн, худлыг сонсолгүй 25 жилийн ял өгөхөд сэтгэл санааны цочирдолд орсон байх. Шүүх хурлыг нээлттэй явуулахыг бид ч ялгаагүй хүсч байгаа. Тэр хохирогчийн талын хүмүүс бидэнтэй мөн адил үнэн мөнийг тодруулахаар ажиллаасай гэж бодож байна. Бид хүүгээ хилсээр буруутан болгож байна, тэд хүүгээ алдсан. Хэргийг үнэн зөвөөр шийдэхийг хүсч байгаа. Одоо шүүх хурлын тогтоол гарсны дараа бид давж заалдах шатны шүүхэд хандана. Тогтоол нь чухам хэзээ гарах юм байгаа юм. Хүлээж л байна. Бид гэмгүй хүмүүсийг гүтгэж үндэслэлгүйгээр ялласан энэ шүүхийн шийдвэрийг эсэргүүцэж байгаагаа илэрхийлж, ард түмнийг дуу хоолойгоо нэгтгэхийг уриална. Үзэл бодлоо илэрхийлэх тайван жагсаал цуглаан зохион байгуулахаар зөвшөөрлөө авчихаад ирлээ. Тайван жагсаал энэ сарын 07-ны бямба гарагт Эрдэнэт хотын Соёлын өргөөний гадна талбайд хийнэ. Энэ хэргийг нээлттэй хэлэлцэхийг хүсч байгаа хүмүүс цуглах байх гэж бодож байна" гэжээ.

Дугаарын **60** мөр

# Ажлаа хийж чадахгүй байж битгий самраад бай

**Үргэлжлэл.**
**Түрүүч нь I нүүрт**

Г.Туваан, Б.Дэмбэрэл, С.Шаадай, Д.Ням-Осор нарын үед хүн амын эрүүл мэндийн гол гол үзүүлэлт урьд хожид үзэгдээгүй амжилтад хүрсэнийг түүх гэрчилнэ. Түүнээс хойш төр нийгэм солигдлоо ч гэсэн эмнэлэг анагаах ухааны талаар тавьсан зорилт нь нэгэнт л хүнийг эрүүл байлгах, өвчин эмгэгээс сэргийлэх, хөдөлмөрийн чадвараа алдалгүй өндөр наслуулах, халдварт өвчнүүдийг бууруулах гээд өмнөө тавьсан зорилт нь ижилхэн болохоор энэхүү ажил улам сайжрах ёстой гэж эмч мэргэжилтэн бид үздэг" хэмээн Монгол Улсын Хүний гавьяат эмч Б.Морх гуай ярьж байсан нь эдүгээ ч тод санагдаж байна. Тэгвэл үүнээс хойш буюу зах зээлийн системд шилжсэнээс хойш эдүгээг хүртэл эрүүл мэндийн салбар тухайн үеийн пүүс компаниудын нэгэн адил дампуурч, өнөөдөр элгээрээ хэвтчихээд байгааг хэн хүнгүй мэдэж байгаа. Бүр өвчиндөө дарлуулсан ард түмэн хэлэх үггүй болтлоо аргаа барж буй. Угтаа Эрүүл мэндийн сайд бол эрүүл мэндийн салбар, байгууллагуудынхаа ураг тархи, нүд чих, алсын хараа нь болж, төрөөс өгсөн төсвийг үр ашигтай, шаардлагатай газар нь оножс зарцуулах, оношлогоо эмчилгээ урьдчилан сэргийлэх хамгийн дэвшилттэй арга барилыг өөрийн улсын эмнэлэгтээ нэвтрүүлэх, хөдөө орон нутагт эмнэлгийн үйлчилгээ ямар байгааг өөрийн нүдээр үзэж, эмч мэргэжилтнүүдийн санал бодлыг сонсож мэдээлэл авсанаар хаана ямар барилга байгууламж, тоног төхөөрөмж машин унаа, эм бараа хэрэгтэй байгаа, хөдөө сумдад эмчийн хүрэлцээ одоо болтол яагаад хангагдахгүй байгаа зэргийг зохицуулж байх үүрэгтэй байлтай. Гэтэл энэ үүргээ умартсан Эрүүл мэндийн сайд нар солигдох бүртээ өөрийн талын хүнийг өнөөх эмнэлгийн байгууллагууддаа даргаар тавьж, халаа сэлгээ хийж, арай гэж тогтворжих гэж буй байгууллагыг "самарч" орхидог л ажил хийдэг боллоо. Шинээр томилогдсон дарга нар мэдээжийн хэрэг өөрийнхөө хүмүүсээр багаа бүрдүүлэх нь дамжиггүй. Ингээд л шат шатны эмнэлгүүд шинэ даргын нүүр үзэж, даргадаа таалагдаагүй чадварлаг эмч нар "лааз өшиглөх" нь бий. Тэгвэл он гарахын өмнөхөн хэд хэдэн томилгоо хийж, амаржих газруудын дарга нарыг сольсон байна. Одоогоор хоёр, гуравдугаар амаржих газар буюу нийслэлийн Хүрээ, Амгалан амаржих газрын дарга нарыг томилчихсон юм байх. Тодруулбал, Хүрээ амаржих газрын дарга Б.Оюунхандыг үүрэгт ажлаас нь чөлөөлж, оронд нь Ерөнхий эмчийн үүрэг гүйцэтгэгчээр Ж.Оюунцэцэг гэдэг хэл аманд орооцолдож, АТГ-ын шалгалтад бүдэрч байсан хүнийг томилсон бол Амгалан амаржих газрын дарга Д.Бат-Очирын оронд Ц.Батболд гэдэг хүнийг томилсон байна. Мэдээжийн хэрэг тэд эрүүл мэндийн салбарт ажиллаж байсан туршлагатай боловч яг жирэмсэн эхийг төрүүлж, эх барьж байсан хүмүүс биш гэж цаагуур чинь яриад эхэлчихжээ. Бүр зарим нэг мэргэжлийн хүмүүс "Төрөхийн дарга нар амьдралдаа хүн төрүүлж үзээгүй, хотын төрөх эмнэлэгт ажиллаж үзээгүй хүмүүс болсон гэж ойлгоод байна" хэмээн бичсэн байх юм. Түүгээр ч барахгүй "Германд төрөх эмнэлгийг мэргэжлийн бус хүн удирдсан бол гэмт хэрэг гэж үздэг юм" гэх зэргээр байр сууриа илэрхийлжээ. Яадаг ч байсан, огт мэргэжлийн бус хүн тавиагүй нь лавтай. Харин тэр хүн төрүүлж, гардан эх барьж үзээгүй байдаг нь л юу юм гэхээс. Тэгэхдээ өөрөө зовлонг нь мэддэг хүн тухайн байгууллагад ажиллаж буй эмч, ажилчдынхаа зовлон жаргалыг ойлгох хэрэгтэй гэдэг утгаараа л үүнийг бичсэн байх. Ер нь ч тэгээд элгээрээ хэвтчихээд байгаа эрүүл мэндийн салбарыг үндсээр нь л өөрчилдөггүй юм бол хэдэн эмнэлгийн даргыг ээлжилж солиод эрүүл мэндийн салбар өндийнө гэдэг ч үлгэр биз дээ. Үнэндээ эрүүл мэндийн салбар бол мэргэжлийн бус хүнээр жолоодуулсан нисэх онгоц л гэсэн үг болоод байна шүү. Хэзээ ч сөнөж мэдэхээр л байна.

ЗАСГИЙН ГАЗАР

# "Аялал жуулчлалын хөгжлийн төв" байгууллаа

Ж.МЯГМАР

Засгийн газрын ээлжит хуралдаанаар дараахь асуудлуудыг шийдвэрлэлээ. Тухайлбал, Аялал жуулчлалын салбараа хөгжүүлснээр эдийн засгийг төрөлжүүлэх, гадаад валютын урсгал, экспортыг эрс нэмэгдүүлэх замаар тогтвортой, ногоон хөгжлийг бүрдүүлэх боломж бүрдэнэ. Иймээс "Аялал жуулчлалын хөгжлийн төв" төрийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар байгуулах Засгийн газрын тогтоол баталсан байна. Үйлдвэрийн газар нь Байгаль орчин, аялал жуулчлалын яамны дэргэд аялал жуулчлалын салбарын бодлогын хэрэгжилтийг хангаж, яамны ажилд дэмжлэг үзүүлэх, төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх, статистик мэдээ, мэдээллийг нэгтгэн боловсруулж, судалгаа, дүн шинжилгээ хийх, зорилтот зах зээлээ тодорхойлох, олон улсад гадаад сурталчилгаа хийх, жуулчдад зориулсан бүтээгдэхүүн, үйлчилгээг сайжруулах зэрэг чиглэлээр ажиллах ажээ. Дэлхийн 97 улсын 60 нь буюу 62 хувь нь аялал жуулчлалын үндэсний байгууллагатай байна. Манай улсад аялал жуулчлалын хөгжлийн талаар баримталж байгаа бодлого, хөтөлбөрүүдийн хэрэгжилт, үр дүн хангалтгүй байгаа нь тусгайлсан чиг үүрэг бүхий төрийн байгууллагын бүтэц байхгүйтэй шууд холбоотой гэж салбарын яам үзжээ. 2015 оны байдлаар дэлхийд 1.3 тэрбум гаруй хүн аялсан бол 2030 он гэхэд 1.8 тэрбумд хүрэх таамаглал гарчээ. Аялал жуулчлалын салбар нь дэлхийн нийт бүтээгдэхүүний 10, худалдаа үйлчилгээний 30, татварын орлогын таван хувийг эзэлж, 11 хүн тутмын нэгийг ажлын байраар хангадаг байна.

## Монголд ирэх бүлэг жуулчдад визийн хөнгөлөлт үзүүлнэ

Гадаадын зочид, жуулчдын урсгалыг нэмэгдүүлэх зорилгоор Засгийн газар хоорондын болон салбарын яам хоорондын санамж бичиг, гэрээг үндэслэн аялал жуулчлалын компаниудаар зуучлуулан ирэх гадаадын бүлэг жуулчдад Монгол Улсад зорчих визийн хөнгөлөлттэй нөхцөл олгох Засгийн газрын тогтоол баталлаа. Мөн дамжин өнгөрөх гадаадын иргэнд дараагийн улсад зорчих виз, нислэгийн тийзийг үндэслэн Монгол Улсад 72 цагийн хугацаанд визгүй зорчих орчин бүрдүүлэх, Засгийн газрын энэ тогтоолд хяналт тавьж ажиллахыг холбогдох сайд нарт даалгасан байна. Цаашид Монголын үндэсний агаарын тээвэрлэгч компанийн шууд нислэгтэй чиглэлээс ирэх гадаадын жуулчдын нислэгийн үнэ тарифыг жил бүрийн аравдугаар сарын 01-нээс дараа оны тавдугаар сар хүртэл бууруулах, хөнгөлөлт үзүүлэх чиглэлээр тодорхой ажлууд зохион байгуулахыг Зам, тээврийн хөгжлийн сайдад үүрэг болгожээ.

## Хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл боловсруулна

"Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл" боловсруулж, батлуулах ажлыг Удирдан зохион байгуулах Үндэсний хороог Монгол Улсын Ерөнхий сайдаар ахлуулан байгуулав. Төсөл боловсруулахад шаардагдах хөрөнгийг улсын төсөв, гадаад орон, олон улсын байгууллагаас хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрт хамруулах болон бусад эх үүсвэрээс гаргахаар тооцоолж байна. Хүн амын механик өсөлт, эдийн засаг, нийгмийн хөгжил, аж үйлдвэр эрчимжсэнээр нутаг дэвсгэр, хүн амын нутагшилт, суурьшилд томоохон өөрчлөлт орж, иргэдийн амьдралын хэв маяг өөрчлөгдөн, экологийн нөхцөл ч муудаж байна. Хүн амыг нутаг дэвсгэртээ оновчтой нутагшуулан суурьшуулах, үүнтэй холбогдож гарах олон асуудлыг шийдвэрлэхийн тулд төсөл боловсруулах шаардлага гарчээ.

# СПОРТ

# НҮБ, МЕКСИК Д.ТРАМПТАЙ ХАМТРАХЫГ ХҮСЭВ



**Үргэлжлэл.**
**Түрүүч нь I нүүрт**

Энэ онд дэлхий дахинаа болох 10 гол үйл явдлын нэг нь яах аргагүй, НҮБ-ын болон АНУ-ын шинэ тэргүүнүүд тангаргаа өргөж, үүрэгт ажилдаа орох явдал. Тэгвэл 2016 он улирч, 2017 он гарсны эхний өдөр НҮБ-ын шинэ Ерөнхий нарийн бичгийн дарга Антонио Гутерреш тангаргаа өргөсөн. Харин энэ сарын 20-нд үл хөдлөх хөрөнгийн тэрбумтан Доналд Трамп АНУ-ын 45 дахь Ерөнхийлөгчийн тангараг өргөж, Цагаан ордонд нүүж очих билээ. Тэгвэл НҮБ-ын тэргүүн А.Гутерреш тус байгууллагын үүрэг, үйл ажиллагааг хатуухан шүүмжилж буй АНУ-ын дараагийн Ерөнхийлөгчтэй анх удаагаа утсаар ярьжээ. Энэ үеэр ажил хэрэгч байдлаар хэлэлцүүлэг өрнүүлж буйг нь сайшаахын ялдамд цаашдаа үр дүнтэй ажиллаж, АНУ тэргүүтэй холбоотон улс орнуудын НҮБ-д итгэх итгэлийг сайжруулах бодолтой байгаагаа илэрхийлсэн байна. Энэ талаар НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргын хэвлэлийн төлөөлөгч нь олон нийтэд мэдээлжээ. АНУ-ын Нью-Йорк хот дахь төв байрандаа тэрбээр хэвлэлийн хурал зарлаж, хэвлэлийнхэнд хоёр тэргүүний хоорондын ярианы талаар мэдэгдсэн аж. Ингэхдээ “НҮБ, АНУ-ын харилцааны талаар илэн далангүй ярилцсан. Ерөнхий нарийн бичгийн дарга А.Гутерреш Доналд Трамп Ерөнхийлөгчтэй нягт харилцаатай байхаа илэрхийлсэн” гэж тайлбарлажээ. Нөгөөтэйгүүр, Доналд Трампын засаглалын Цагаан ордны хэвлэлийн төлөөлөгч ч мөн хэвлэлийн хурал зарлаж, утсаар ярьсан талаар мэдэгджээ. Тэрбээр “Д.Трамп АНУ-ын татварыг үр дүнтэй, оновчтой зүйлд зарцуулахыг НҮБ-аас хүссэн” хэмээсэн байна. Д.Трамп Ерөнхийлөгчийн тангаргаа өргөвөл АНУ-ын хамгийн их хандив өгч буй НҮБ-ын төсвийг оновчтойгоор ашиглахыг шаардана гэдгээ ч энэ үеэр илэрхийлжээ.

## D витамин худалдаалахыг хоригложээ

Францын Эрүүл мэндийн яамнаас тус улсын эмийн “Crinex” компанид үйлдвэрлэсэн “Uvesterol D” буюу шингэн D витаминыг хэрэглэсэн дөнгөж төрсөн нярай хүүхдийн амьсгал нь боогдож нас барсантай холбогдуулан түр хугацаагаар тус бүтээгдэхүүнийг худалдан борлуулахыг хориглож буйгаа мэдэгдлээ.

Францад ерөнхийдөө “Uvesterol D”-г D витамины дутагдалтай төрсөн хүүхдүүдэд аманд нь дусаах хэлбэрээр хэрэглэдэг байна. Гэвч өнгөрсөн жилийн арванхоёрдугаар сарын 21-нд 10 хоногтой нярай уг вакцинаас үүдэн амьсгал хураасан харамсалтай хэрэг гарчээ. Нярайн аманд вакциныг дусаасны дараа амьсгал нь боогдож, улмаас нас барсан байна. Харин шинжилгээ хийхэд, нярайн үхлийн шалтгаан нь “Uvesterol D”-г залгисантай холбоотой байх магадлалтай гэсэн дүн гарчээ. Тиймээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний хүрээнд тус витаминыг тодорхойгүй хугацаагаар худалдан борлуулахыг хориглолоо. Францын Эрүүл мэндийн сайд Марисол Турайне “Хамгийн гол эрсдэл нь D витаминдаа бус, хэрэглэх аргад нь л байгаа юм” гэдгийг тодотгожээ. “Uvesterol D”-г гадаадын өөр улс оронд худалдан борлуулдаггүй аж.

## Францын 105 настай эрэгтэй дэлхийн хамгийн хөгшин дугуйчин болов

Унадаг дугуйгаар нэг цагт хэчнээн зайг туулж чадах вэ гэх тэмцээнд 1911 онд төрсөн эдүгээ 105 настай Роберт Марчард гэх франц эрхэм оролцжээ. Гал сөнөөгчөөр ажиллаж байгаад гавьяаныхаа амралтад гарсан тэрбээр 60 наснаасаа хойш дугуйн спортын тэмцээнүүдэд оролцож эхэлсэн байна. Гурван жилийн өмнө гэхэд 102 насандаа нэг цагт 27 км хүртэл хурдалж, дээд амжилт тогтоож байв. Учир нь 100 гаруй насандаа ялангуяа унадаг дугуйгаар ийм хэмжээний зайг туулсан өөр хүн байхгүй юм. Тэгвэл энэ удаа 105 насны босго алхсан Р.Марчард Парис хотын зах хэсэгт болсон дугуйн уралдаанд оролцож, дахин дээд амжилт тогтоолоо.

Нурууны хэсэгтээ “105” гэж бичсэн шар өнгийн өмсгөлтэй тэрбээр олон хүний дэмжих уухайн түрлэг дунд нэг цагт 22.5 км хурдалжээ. Түүний хувьд хэдийгээр өмнөх амжилтаа эвдэж чадаагүй ч, 105 насандаа нэг цагт 22.5 км хурдалсан дэлхийн анхны тамирчин болж байгаа юм. Тэмцээн дуусах мөчид “10 минут үлдлээ гэх дохиог харсан даруйдаа хурдаа нэмсэн. Сайн үр дүн гарлаа” хэмээн сэтгэгдлээ илэрхийлжээ. Эдүгээ 105 настай ч, эрүүл саруул амьдарч буй шалтгаанаа тэрбээр өдөр бүр жимс хүнсний ногоо их идэж, дасгал хөдөлгөөн хийсний ач тус гэж тайлбарласан гэнэ.

## №9: Өндөр насны тэтгэвэр, тэжээгчээ алдсаны тэтгэвэр, тахир дутуугийн тэтгэврийн онцлог

Манай сонин долоо хоног бүрийн баасан гарагт нийгмийн даатгалын үйлчилгээ, түүний талаархи түгээмэл асуулт хариултын буланг Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллага /ЖАЙКА/-ын Монгол Улсад хэрэгжүүлж буй Нийгмийн даатгалын үйл ажиллагааны чадавхийг бэхжүүлэх төслийн мэргэжилтнүүдтэй хамтран бэлтгэн хүргэж байгаа билээ. Уншигчдын төдийлөн мэддэггүй ч, заавал мэдэж байх ёстой түгээмэл асуултад Нийгмийн даатгалын үйл ажиллагааны чадавхийг бэхжүүлэх төслийн ахлах зөвлөх Ямашита Маморү хариулж байна.

**-Японы өндөр насны тэтгэвэр, тэжээгчээ алдсаны тэтгэвэр, тахир дутуугийн тэтгэвэрийн талаар манай уншигчдад мэдээлэл өгөхгүй юу?**

-Японы өндөр насны тэтгэврийн зарчимд 25 жил тэтгэврийн даатгалын шимтгэл төлөөгүй хүн 65 наснаас тэтгэвэр тогтоолгох эрхгүй байдаг. Тухайлбал, шимтгэл төлсөн хугацаа нь 24 жил байсан ч, тэтгэвэр авах боломжгүй гэсэн үг. 24 жил төлсөн байхад хүртэл шүү дээ.

Гэхдээ тэтгэвэр авахын тулд хугацаагаа уртасгах, мөн 10 жилээр багасгаж болдог. Энэ тохиолдолд 10-аас дээш жил шимтгэл төлсөн хугацаагаа тооцуулж, тэтгэвэр авах боломжтой ч, энэ мөнгө нь 25 жил шимтгэл төлсөн хүнийхтэй харьцуулахад мэдээж бага байна. Тахир дутуугийн тэтгэврийн талаар тайлбарлая. Тодорхой хугацаанд даатгалын шимтгэл төлж байсан хүн тахир дутуугийн тэтгэвэр авах шаардлага хангадаг. Гэхдээ тэтгэвэр нь тахир дутуугийн зэргээс хамаарч янз бүр байна. Хүнд гэмтсэн тохиолдолд хэвийн хэмжээнээс их байхаар тогтоодог. Мөн ямар хугацаанд нийгмийн даатгалын шимтгэл төлсөн эсэх нь хамаагүй. Шимтгэл төлж эхлээд удалгүй осолд өртсөн байсан ч, тэтгэмж нь багасна гэсэн ойлголт байхгүй. Сүүлийнх нь тэжээгчээ алдсаны тэтгэвэр. Тэжээгчээ алдсаны тэтгэвэр авах шаардлагын тухайд тодорхой хугацаанд нийгмийн даатгалын шимтгэл төлсөн байх ёстой. Мөн хүүхдийн тоо, нас зэргээс хамаарч тэтгэмжийн дүн нь нэмэгддэг. Тахир дутуугийн тэтгэмжтэй адил хэр хугацаанд нийгмийн даатгал төлснөөс хамаарч тэтгэвэрт өөрчлөлт орохгүй. Өөрөөр хэлбэл, тэтгэврийн даатгалд хамрагдсаныхаа яг дараа аливаа эрсдэл өртсөн тохиолдолд ч тэтгэмжийн хэмжээ багасахгүй.


## АГААН САРЫН ХЯМДРАЛ - ДОТНЫ ХҮМҮҮСТЭЭ ОЧИХ ЗАМ ТАНЬ ӨЛЗИЙТЭЙ БАЙХ БОЛТУГАЙ

Монголын уламжлалт сар шинийн баярыг тохиолдуулан Хүннү Эйр ХХК 2017 оны 1 сарын 9 ний өдрөөс эхлэн орон нутгийн дараах чиглэлийн нислэгийн тийзэнд хямдрал зарлаж байна.

**ХАМГИЙН ХЯМДДАА**

**Улаанбаатар - Увс - Улаанбаатар**
1 талдаа – 141 200 төгрөг
2 талдаа – 277 800 төгрөг,

**Улаанбаатар - Ховд - Улаанбаатар**
1 талдаа – 137 000 төгрөг
2 талдаа – 269 500 төгрөг,

**Улаанбаатар - Баян-Өлгий – Улаанбаатар**
1 талдаа – 149 500 төгрөг
2 талдаа – 294 300 төгрөг,

**Улаанбаатар - Завхан - Улаанбаатар**
1 талдаа – 144 700 төгрөг
2 талдаа – 261 800 төгрөг,

**Улаанбаатар - Дорнод - Улаанбаатар**
Нэг талдаа - 114500 төгрөг,
Хоер талдаа - 224500 төгрөгөөс эхэлж байгаа ба хямд тийз хязгаартай тул Та тийзээ амжиж эрт худалдан аваарай



## УРИЛГА

**БНХАУ-ЫН ТЯНЬЖИН БООМТЫН ДУНЗЯНЫ ЧӨЛӨӨТ ХУДАЛДААНЫ БООМТ БҮСЭД ХЭРЭГЖҮҮЛЭХ ТЭЭВЭР ЛОЖИСТИКИЙН ТӨСӨЛД ХАМТРАН АЖИЛЛАХ ТУХАЙ**

Монгол Улсын Засгийн газрын “Далайд гарах боломжийг нэмэгдүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” 2013 оны 152 дугаар тогтоолын хүрээнд БНХАУ-ын Тяньжин хотын Дунзян чөлөөт худалдааны боомт бүсийн 10 га газарт Хятадын талтай хамтарсан компани байгуулж “Тээвэр ложистикийн төв” төслийг хэрэгжүүлэх, энэхүү төсөлд хөрөнгө оруулж, хамтран ажиллах боломж бүхий дотоодын хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдийг хамтран ажиллахыг урьж байна.

**Санал ирүүлэх компаниудад тавигдах шаардлага**
-Компани татварын өргүй;
-Санхүүгийн чадамжтай;
-Тогтвортой, удаан хугацаанд хамтран ажиллах.

**Санал авах хугацаа**
Саналыг 2017 оны 2-р сарын 15-ны өдрийг хүртэл хугацаанд “Монголын төмөр зам” ТӨХК-д албан бичгээр эсвэл baigalmaa@mtz.mn цахим хаягаар ирүүлнэ үү.

**Хаяг:**
**“Монголын төмөр зам” Төрийн Өмчит Хувьцаат Компани**
**Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Энхтайвны өргөн чөлөө-23, UBH центр, 8-р давхар**
**Улаанбаатар 14230**
**Утас: (976) 99140072**
**Факс: (976) 70106644**
**Вебсайт: www.mtz.mn**



# Б.ТУНГАЛАГ: Миний зорилго Токиогийн Олимпийн наадамд оролцох

Н.ПУНЦАГБОЛД

*48 кг-ын жинд Монгол Улсын рекордыг 50 орчим удаа эвдээд байгаа хүндийн өргөлтийн тамирчин Б.Тунгалагтай ярилцлаа.*

**-Хүндийн өргөлтийн насанд хүрэгчдийн улсын аварга шалгаруулах тэмцээн энэ сарын 3, 4-ний өдрүүдэд болж өндөрлөлөө. Өөрийн тань хувьд 48 кг-д түрүүлсэн. Тэмцээний талаар ярьвал?**

-Хүндийн өргөлтийн холбоо энэ оны хамгийн анхны тэмцээнээ зохион байгууллаа. Би энэ тэмцээний салхийг хагалсан. Ерөөс 48 кг-ынхан тэмцээнийг нээдэг юм. Тиймдээ ч би энэ оны анхны тэмцээнийг нээсэн. Бас хамгийн анхны медалийг авч, улсын рекордыг шинэчилсэндээ маш их баяртай байгаа. Тэмцээн их сайхан боллоо. Олон рекорд эвдэгдсэн. Найман тамирчин улсын дээд амжилтыг эвдсэн.

**-Танай жинд хэчнээн тамирчин оролцсон бэ. Өрсөлдөгчид хэр хүчтэй байв?**

-48 кг-ын жинд 5-6 тамирчин оролцсон. Харьцангуй цөөхөн л дөө. Нэг охин спортын дэд мастерын зэрэг хангасан. Өрсөлдөгчдийн хувьд үнэхээр мундаг байсан. Үргэлж л мундаг байдаг юм. Би энэ удаагийн тэмцээнд нийлбэр дүнгээр 155 кг өргөсөн. Хоёрдугаар байрт шалгарч, спортын дэд мастерын болзол хангасан охин гэхэд огцом болон түлхэлттэй өргөлтийн нийлбэр дүнгээр 105 кг өргөсөн.

**-Одоогоор аль клубт харьяалагдаж бэлтгэл сургуулилтаа хийж байна?**

-Төрөлжсөн сургалттай биеийн тамир спортын дунд сургуульд суралцдаг. Одоо төгсөх ангийн сурагч. Мөн “Аврагч” спорт хороонд харьяалагдаж бэлтгэлээ хийдэг. Сургуулиа төгсөөд Цагдаагийн академд орж суралцах бодолтой байгаа даа.

**-Хүндийн өргөлтийн спортоор хэчнээн жил хичээллэж байна. Яагаад энэ спортыг сонгосон юм бэ?**

-Дөрвөн жил хичээллэж байна. Анх наймдугаар ангид байхдаа л энэспортоортуушталхичээллэж эхэлсэн. Манай хамаатны ах, эгч нар маань спортын хүмүүс байдаг. Тэр жил хүндийн өргөлтийн өсвөрийн улсын аварга шалгаруулах тэмцээнд Улаанбаатар хотод болсон. Би тэр тэмцээнийг Багануураас ирж үзсэн юм. Тэгэхэд надад үнэхээр сонирхолтой санагдсан. Түүнээс хойш спортоор хичээллэе гэж бодоод л хүндийн өргөлтийг сонгосон. Надаас жаахан хүүхдүүд тэр тэмцээнд медаль авч байсан. Тэгээд би ч чадах юм байна, их сонирхолтой спорт юм шиг санагдаад л хичээллэж эхэлсэн дээ.

**-Хүндийн өргөлт гэдэг тийм ч амар спорт биш шиг санагддаг. Тэр дундаа эмэгтэй хүүхэд энэ спортоор хичээллэхэд аав, ээж чинь яаж хүлээж авч байв?**

**Үргэлжлэл нь VII нүүрт**



Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

## Мөсөнд авиралтынхан Бээжинг зорилоо

БНХАУ-ын Бээжин хотноо энэ сарын 7-9-ний өдрүүдэд мөсөнд авиралтын “Дэлхийн цом”-ын аварга шалгаруулах тэмцээн болох учиртай. Тэгвэл Монгол Улсаа төлөөлөн спортын мастер Л.Нямбаяр, спортын дэд мастер Н.Хэрлэн, тамирчин Д.Отгонхүү нар өрсөлдөхөөр өчигдөр Бээжинг зорилоо. “Дэлхийн цом”-ын тэмцээнд манай тамирчид хурд болон техникийн гэсэн хоёр төрөлд оролцохоор мэдүүлгээ өгсөн юм байна. Мөн энэ тэмцээний үеээр мөсөнд авиралтын шүүгч бэлтгэх олон улсын сургалт зохион байгуулагдаж байна. Энэ сургалтад МУҮХ-ны шүүгчдийн зөвлөлийн дарга Д.Батболд, мөсөнд авиралтын хороон гишүүн С.Дэлгэрмөрөн нар оролцож, “Дэлхийн цом”-ын тэмцээнд шүүгчээр ажиллах ажээ.

## "Монгол бөхийн өргөө"-нд энэ сард гурван томоохон барилдаан болно

2017 оны эхний барилдаан энэ сарын 13-нд Монгол Улсын ардчилсан шинэ Үндсэн хууль батлагдсаны 25 жилийн ойд зориулсан барилдаанаар эхлэх аж. Тэгвэл үүнээс хоёр хоногийн дараа “Талх чихэр” хувьцаат компаниас зохион байгуулдаг “Хэвийн боовны баяр”-ын барилдаан болно. Мөн Харцага цолтонд хүндэтгэл үзүүлэх барилдаан сарын сүүлээр болохоор товлогдсон байна. “Талх чихэр” хувьцаат компаниас зохион байгуулдаг уламжлалт “Хэвийн боовны баяр” буюу аймаг, цэргийн цолтой 256 бөхийн барилдаан энэ сарын 15-нд болох юм. Тэгвэл Монгол Улсын харцага цолтонд хүндэтгэл үзүүлэх улс, аймгийн алдар цолтой 224 бөхийн барилдаан энэ сарын 22-нд болохоор тов гарчээ.

## Бяцхан тамирчиддаа хүндэтгэл үзүүллээ

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Биеийн тамир, спортын газар /БТСГ/-ын дарга, Гавьяат тамирчин Ц.Шаравжамц өчигдөр шатар болон даамын спортын тив, дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд өндөр амжилт үзүүлсэн өсвөрийн тамирчдыг хүлээн авч, хүндэтгэл үзүүллээ. Энэ үеэр Туркийн Измир хотод болсон 100 буудалт даамын ДАШТ-ээс алтан медаль хүртсэн М.Шийрэвжамцийг БТСГ-ын тэргүүн шагнал “Алтан Од”-оор шагнав. Мөн тус арга хэмжээнд хүрэлцэн ирсэн багачуудад БТСГ-ын дарга Ц.Шаравжамц, Төрийн захиргаа, санхүү, удирдлагын хэлтсийн дарга Ц.Одонбаяр нар гарын бэлэг гардуулж, спортын өндөр амжилт хүслээ.

## Чөлөөт бөхийн улсын аварга шалгаруулах тэмцээн маргааш эхэлнэ

Чөлөөт бөхийн насанд хүрэгчдийн УАШТмаргааш “Буянт-Ухаа” спортын ордонд эхэлнэ. Уг тэмцээнд Гавьяат тамирчин Г.Мандахнаран барилдах бол Гавьяат тамирчин Э.Бэхбаяр өнжихөөр болжээ. Дэлхийн аваргын хошой хүрэл медальт, олимпийн наадмын шагналт V байрын эзэн Г.Мандахнаран энэ жилээс жин өгсөж, 70 кг-д барилдахаар болсон байна. Түүний хувьд Риогийн наадамд 65 кг-д барилдаж, хүрэл медалийн төлөө Узбекистаны бөхөд харамсалтайгаар ялагдсан юм. Тэгвэл энэ жилийн УАШТ-ийг дэлхийн аваргын мөнгөн медальт Э.Бэхбаяр өнжихөөр болсон. Учир нь тэрбээр өнөөдөр Энэтхэгт эхэлж байгаа “Pro Wrestling League season” лигийн тэмцээнд оролцож байгаа юм. Түүнээс гадна Ж.Чулуунбат, Д.Хүдэрбулга зэрэг манай шилдэг тамирчид улсын аваргаа өнжих юм байна. Ж.Чулуунбатын хувьд оны өмнөхөн ШШГЕГ-ын харьяа “Сүлд” спорт хорооны чөлөөт бөхийн дасгалжуулагчаар томилогдсон юм байна. Тиймээс 2017 оны УАШТ-нд “Сүлд”-ийн тамирчдаа бэлтгэж оролцуулах бөгөөд нөгөө талаас олимпийн шинэ цикл эхэлж байгаа тул шинэ залуу тамирчдад боломж олгож, шигшээ багийн бүрэлдэхүүнд дуудагдах замыг нь тавьж өгч байгаа ажээ. Чөлөөт бөхийн УАШТ бямба, ням гарагт болохоо бөгөө МҮОНТ шууд дамжуулах юм байна.

## Шатар сонирхогчдын улсын аварга шалгаруулах тэмцээн болно

Монгол Улсын шинэ Үндсэн хууль батлагдсан өдрийг жил бүрийн нэгдүгээр сарын 13-ны өдөр улс орон даяар тэмдэглэн өнгөрүүлдэг уламжлалтай. Энэхүү өдрийг тохиолдуулан Шатар сонирхогчдын улсын аварга шалгаруулах тэмцээнийг УИХ-ын даргын ивээл дор зохион байгуулаад тав дахь жилтэйгээ золгож байна. Шатар сонирхогчдын улсын аварга шалгаруулах тавь дахь удаагийн тэмцээнийг УИХ-ын Тамгын газар, Монголын шатрын холбоотой хамтран УИХ-ын даргын ивээл дор 2017 оны нэгдүгээр сарын 7-8-ны өдрүүдэд Төрийн ордонд зохион байгуулах гэж байна. Уг тэмцээнд Монголын шатрын холбооноос гаргасан рейтингийн жагсаалтаар сүүлийн хоёр жилийн хугацаанд рейтинг нь 2000-аас дээшгүй, шатрын спортын цолгүй, 18-аас дээш насны шатар сонирхогчид оролцдог. Хоёр үе шаттай зохиогддог энэхүү тэмцээний анхан шатны шалгаруулалт өнгөрсөн оны арваннэгдүгээр сарын дундуур бүх сум, дүүрэгт болж нийтдээ 5100 хүн оролцсон бол хагас шигшээ тоглолт өнгөрсөн 12 дугаар сарын эхээр аймаг, нийслэлийн хэмжээнд явагдаж 987 шатарчин оюун ухаан, авхаалж самбаагаа сорьж өрсөлджээ. Хагас шигшээ тэмцээнд нийслэлээс шалгарсан эрэгтэй 18, эмэгтэй ес, аймаг тус бүрээс шалгарсан эрэгтэй хоёр, эмэгтэй нэг, нийт 90 шатарчин дараагийн шат буюу Шатар сонирхогчдын улсын аварга шалгаруулах тэмцээнд оролцох эрх аваад байна. Эдгээр шатарчид дээр УИХ-ын гишүүд, УИХ-ын Тамгын газар, УИХ-аас удирдлагуудыг нь томилдог болон ажлаа тайлагнадаг байгууллагууд, Үндсэн хуулийн цэц, Ардчилсан Үндсэн хууль тогтоогчдын холбоо зэрэг байгууллагуудыг төлөөлсөн 30 шатарчин нэмэгдэж Шатар сонирхогчдын улсын аваргын төлөө өрсөлдөх юм.



# "ЧЕЛСИ" КЛУБ "АРСЕНАЛ"-ЫН АГУУ АМЖИЛТАД ХҮРЧ ЧАДСАНГҮЙ

Н.ПУНЦАГ

Английн премьер лиг нэгэнт эхний хагасаасаа өнгөрч, 20 дугаар тойргийн тоглолтууд энэ долоо хоногийн дундуур болж өндөрлөлөө. Энэ тойрогт хамгийн их хүлээлт үүсгэж байсан тоглолт нь "Тоттенхэм" талбайдаа хүснэгтийг тэргүүлэгч "Челси"-г хүлээж авах "тулаан" байсан юм. Хамгийн их ач холбогдол бүхий энэ тоглолт өнгөрсөн лхагва гарагийн шөнө болсон. Үүнээс өмнө топ дөрвийн төлөө өрсөлдөж байгаа шилдэг багууд тоглолтоо хийчихээд байсан юм. "Ливерпүүл"-ийг эс тооцвол бусад нь хожсон. Тухайлбал, "Манчестер Сити" даваа гарагийн шөнө талбайдаа "Бөрнли"-г хүлээж авч, 2:1-ээр буулгаж авсан. Хэдийгээр "Сити"-гээс Фернандиньо улаан хуудас авч, хүн дутуу үлдсэн ч өрсөлдөгчөө хожиход саад болоогүй юм. Дөрвөн тоглолт өнжөөд орж ирсэн Агуэро энэ тоглолтод гоол оруулж, энэ улирлын 11 дэх гоолоо оруулсан. Мөн тэргүүлэгчид рүү оноогоор ойртлоо. Харин "Арсенал" клуб энэ тойрогт "Борнмут"-ын талбайд зочилж, 3:3-аар тэнцсэн юм. Эхний үед гурван гоолоор хожигдож байсан ч хоёрдугаар үед барьсан. Санчес премьер лигийн 13 дахь гоолоо оруулсан бол Жиру 90+2 дахь минутад багаа аварсан. Ийн "Арсенал" оноо алдсанаар бүр тавдугаар байр руу ухарлаа. "Манчестер Юнайтед"-ын хувьд энэ тойрогт "Вест Хэм"-ийг талбайд нь 0:2-оор буулгаж авсан. Ингэснээр 39 оноотой болж, 6 дугаар байрт бичигдэж байна. Гэхдээ ирэх хоёр тойрогт хожиж чадвал бусад багуудын оноо алдалтаас шалтгаалж дөрөв рүү ороод ирэх ч боломж байна. Тэгвэл тавдугаар байрт бичигдэж байсан "Тоттенхэм" клуб талбайдаа "Челси"-г 2:0-ээр буулгаж авч, 42 оноотой болсноор гуравдугаар байр руу орж ирсэн юм. Оны өмнөхөн "Челси" талбайдаа "Тоттенхэм"-ийг 2:1-ээр арай гэж буулгаж авсан. Харин хэдхэн тойргийн дараа "Тоттенхэм" хариугаа авч чадлаа. Тоглолтын хувь заяаг шийдсэн хоёр гоолыг Деле Алли 45, 54 дэх минутад оруулсан юм. Хоёр гоолыг дамжуулалтыг хоёуланг нь Кристиан Эриксен өгсөн. Харин Алли хоёр гоолоо мөргөж оруулсан. Ингэснээр Деле Алли премьер лигт 10 гоолтой болж, Харри Кейний хамтаар мэргэн буучийн жагсаалтын зургадугаар эгнээнд бичигдэж явна. Түүнээс гадна Англи эр сүүлийн гурван тоглолтод дубль хийж байгаа юм. Тодорхой хэлбэл, гурван тоглолтод зургаан гоол оруулсан юм. "Челси"-гийн хаалганд хоёр гоол оруулахаас өмнө тэрбээр "Саутгэмптон"-ыг 4:1-ээр хожиход хоёрыг, ""Уотфорд"-ыг 4:1-ээр буулгаж авахад мөн дубль хийсэн юм. Түүнээс гадна "Бөрнли" клубыг 2:1-ээр хожиход хоёр гоол оруулж байсан юм. Ингэснээр премьер лигийн 20 тойрогт дөрвөн удаа дубль хийгээд байна. "Челси"-гийн хувьд Английн премьер лигт 13 дараалан хожиж, "Манчестер Юнайтед"-ын 12 дараалж хожсон амжилтыг эвдээд байсан юм. Харин "Арсенал" клуб 14 тоглолт дараалан хожсон агуу амжилтыг үзүүлж байсан түүхтэй. Энэхүү түүхэн амжилтыг эвдэхэд ердөө хоёрхон тоглолт үлдээд байсан энэ үед "Тоттенхэм" зогсоолоо. Оны өмнө энэ хоёр баг хоорондоо учраа таарахад "Челси" таван тоглолт дараалан гоол алдаагүй байсан амжилтыг мөн "Тоттенхэм" зогсоож байсан билээ. "Челси" 20 дугаар тойрогт хэдийгээр хожигдсон ч гэсэн 49 оноотой учраас хүснэгтийн тэргүүнд заларсан хэвээр үлдэж байгаа юм. Тэдний араас "Ливерпүүл" таван оноо алдаж нэхэж байна. Уг нь энэ тойрогт "Ливерпүүл" хожиж чадсан бол хоёр багийн онооны зөрүү гурав болж ойртох байлаа. Харамсалтай нь "Улаанууд" оноогоор ойртох боломжоо өөрсдөөсөө болоод алдчихсан юм. 20 тойргийн дараах байдлаар шилдэг зургаан баг хүчтэй өрсөлдөж байна. Тэгвэл "Халл" 13, "Суонси", "Сандерланд" 15 оноотой унах бүсэд бичигдэж байгаа юм.

## "Боруссия Дортмунд": "Шанхай Теллэйс" Обамеянгийн төлөө 150 сая евро санал болгоогүй

Германы "Боруссия Дортмунд" клубын довтлогч Пьер-Эмерика Обамеянгийг Хятадын "Шанхай Теллэйс" клуб 150 сая еврогоор авах санал тавьсан талаар мэдээлэл гарсан билээ. Тэгвэл "Боруссия Дортмунд"-ын хэвлэлийн төлөөлөгч Саша Флигге энэ мэдээллийг үгүйсгэж, түүний төлөө 150 сая евро санал болгоогүй гэж хэлжээ. Гэхдээ хувь тоглогчид жилд 41 сая еврогийн цалин өгөхөөр амласан юм байна. Өдгөө 27 настай Габоны шигшээ багийн тоглогч энэ улиралд "Боруссия Дортмунд"-ын төлөө 22 тоглолтод оролцож, 20 гоол оруулчихаад байгаа юм.

## Эвра "Манчестер Юнайтед"-д эргэж ирэхийг хүсч байна

"Ювентус" клубт тоглож байгаа франц хамгаалагч Патрис Эвра "Манчестер Юнайтед" клубт эргэж ирэхийг хүсч байгаа ажээ. "Улаан чөтгөрүүд"-ийн дасгалжуулагч Жозе Моуриньо өдгөө 35 нас хүрээд буй ахмад хамгаалагчийг авахыг хүсч байгаа юм байна. Тэрбээр "Манчестер Юнайтед" клубт есөн улирал тоглож байсан юм. Италийн хэвлэлүүд түүнийг энэ өвлийн солилцоо наймааны цонхоор "Ювентус"-ыг орхихыг хүсч байгаа талаар мэдээлэлж байгаа юм. Эвра 2014 онд "Манчестер Юнайтед" клубт гараанд гарч чадахгүй байсан учраас Итали руу явж байсан билээ.

## "Ювентус" ирэх зун Верраттигийн төлөө 80 саяыг санал болгоно

Италийн алдарт "Ювентус" клуб энэ улирлын төгсгөлд "ПСЖ" клубын хагас хамгаалагч Марко Верраттиг худалдаж авахаар төлөвлөж байгаа ажээ. Мөн түүнийг Английн "Челси", Италийн "Интер", Германы "Байерн Мюнхэн" клубүүд сонирхож байгаа юм байна. Corriere dello Sport-ын мэдээлж байгаагаар Турин хотын баг өдгөө 24 настай Италийн шигшээ багийн тоглогчийн төлөө 80 сая евро төлөхөд бэлэн байгаа гэнэ. Гэхдээ хоёр багийн хооронд тийм ч тааламжтай харилцаа байхгүй байгаа. 2014 онд Италийн баг "ПСЖ" клубээс Кингсли Команыг авахыг хүссэн ч наймаа бүтээгүй. Харин өнгөрсөн жилийн зун "ПСЖ" Блез Матюидиг зарахаар хэлэлцээр хийсэн ч "Ювентус" хүсээгүй. Верратти энэ улиралд Францийн аварга шалгаруулах тэмцээнд 14 тоглолтод оролцож, хоёр гоол оруулж, нэг оновчтой дамжуулалт өгчихөөд байгаа юм.



## "Реал" 38 тоглолт хожигдоогүй байна

Испанийн алдарт "Реал Мадрид" клуб Испанийн цомын тэмцээний 1/8 шигшээн эхний тоглолтоо "Севилья" клубтэй хийж, 3:0-ээр буулгаж авсан билээ. Ингэснээр 38 тоглолт дараалан хожигдолгүй байж, "Барселона"-гийн амжилттай ойртлоо. "Реал" 38 тоглолтын 29-д нь хожиж, есөн тоглолтод тэнцээд байгаа юм. "Барселона" клубын хувьд 39 тоглолт дараалан хожигдоогүй цувралыг 2015-2016 оны улиралд үзүүлсэн билээ. "Реал Мадрид" хамгийн сүүлд 2016 оны дөрөвдүгээр сарын 6-нд Аваргуудын лигийн ј шигшээд "Вольфсбург" клубын талбайд 2:0-ээр хожигдсон билээ. Түүнээс хойш огт хожигдоогүй яваа юм. "Реал" дараагийн тоглолтоод энэ сарын 7-нд буюу бямба гарагт "Гранада" клубын эсрэг хийх юм. Энэ тоглолтод хожигдохгүй байхад "Барселона"-гийн сүрдэм амжилтыг давтана.

## "Сток" Ли Грантыг худалдан авлаа

Жек Бутландын гэмтэл эдгэрэх шинжгүй, энэ улирлыг бүтэн өнжиж магадгүй байгаа тул "Сток"-ийнхон "Дерби"-гээс зээллэгээр аваад байсан Ли Грантыг 1.3 сая паундаар худалдан авч, үндсэн тоглогчоо болголоо. Эхэндээ 33 настай Ли Грантыг авахдаа ердөө зургаан сарын зээллэгийн гэрээ байгуулсан байсан тул энэ өвөл гарцаагүй сунгах юмуу худалдаж авах шаардлага тавигдсан байна. Одоо тэд Гранттай хоёр жил хагасын гэрээ байгуулжээ. Грант Премьер лигт "Сток"-ийн төлөө 15 тоглолтод гарахдаа зургаан удаад нь хаалгандаа бөмбөг алдаагүй юм.

## Фернандиньо дөрвөн тоглолтоор торгуулав

"Бернли"-гийн эсрэг тоглолтод Йохан Берг Гудмундссон дээр "Сити"-гийн хагас хамгаалагч Фернандиньо бүдүүлэг зөрчил гаргаж, улаан хуудас авсан. "Сити"-гийн удирдлага улаан хуудсыг цуцлуулахаар давж заалдсан ч хуудсыг хүчинтэй үлдээжээ. Ингэснээр бразил хагас хамгаалагч ойрын дөрвөн тоглолтод оролцох эрхгүй боллоо. Фернандиньо энэ улиралд гурав дахь улаан хуудсаа авсан нь энэ бөгөөд Премьер лигт бол хоёр шар хуудас хүртсэн юм. Ингэснээр тэрбээр Английн цомд "Вест Хэм"-тэй, Премьер лигт "Эвертон", "Тоттенхэм"-тэй хийх тоглолтуудыг өнжихөд хүрлээ.

Зар Зар Зар

Цэнгэлдэхийн хажууд "Хурд"-ын байранд 1 өрөө байр зарна

Утас: 96689101

СПОРТ

# Б.ТУНГАЛАГ: МИНИЙ ЗОРИЛГО ТОКИОГИЙН ОЛИМПИЙН НААДАМД ОРОЛЦОХ







Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

**Үргэлжлэл. Түрүүч нь I нүүрт**

-Эхэндээ нэг их дэмжээгүй. Ер нь хүн болгон л “Чи дэмий байх, чадахгүй байлгүй дээ” гэж хэлж байсан. Мөн “Чи өргөдөг юм уу” гэж хүн болгон асуудаг байлаа. Одоо бол “Чи тамирчин юм уу” гэж асуудаг. Анх хүндийн өргөлтөөр хичээллэж эхлэх үед туяхан, жижигхэн охин байсан болохоор хүмүүс “чи чадах юм уу” гэж асуудаг байсан байх л даа.

**-Өмнө нь насанд хүрэгчдийн тэмцээнд оролцож байсан санагдах юм?**

-48 кг бол насанд хүрэгчдийн хамгийн бага жин. Би ирэх наймдугаар сард 18 нас хүрнэ. Өмнө нь хоёр удаа насанд хүрэгчдийн улсын аварга шалгаруулах тэмцээнд оролцож байсан. Хоёуланд нь мөнгөн медаль авч байлаа. Энэ жил анх удаа насанд хүрэгчдийн улсын аварга шалгаруулах тэмцээнээс алтан медаль авч байна. Манай спорт нээлттэй. Насанд хүрээгүй ч гэсэн спортын цол зэрэгтэй байхад насанд хүрэгчдийн тэмцээнд оролцож, өрсөлдөж, өөрийгөө сорьж үзэх боломжтой байдаг.

**-Анх хүндийг өргөлтөөр хичээллэж эхлэх үедээ хэдэн кг өргөдөг байв?**

-Хамгийн анх “Үнэн анд” гэдэг компанийн нэрэмжит тэмцээнд оролцож байсан юм. Тухайн үедээ 23 кг огцомдож, 33 түлхэж байсан. 35 кг-ыг захиалчихаад, цээжин дээрээ гаргаж ирчихээд түлхэж чадаагүй алдчихсан. Ингээд л мөнгөн медаль авч байлаа. Тэр үед наймдугаар ангид л байсан. 36 кг жинд оролцож байсан юм. Тэр үедээ жиндээ хүрэхгүй хувцастайгаа жин дээр зогсч байлаа шүү дээ. Уг нь бол жин дээр хувцсаа тайлаад зогсох ёстой байхгүй юу. Гэтэл миний жин хүрэхгүй байсан учраас өмч байсан хувцастай жин дээр гараад л зогсчихсон. Тэгээд арай гэж 36 кг жинд хүрээд, тэр тэмцээнд оролцож байлаа.

**-Одоо жиндээ хангалттай хүрч байгаа биз дээ. Эсвэл жин хасч байна уу?**

-Одоо шууд л жиндээ орчихдог. Жин хасаад сүйд болоод байдаггүй. Ерөнхийдөө 48 кг-ын жингээ барьж байгаа. Нэг удаа би 48 кг-ын жинд спортын мастер хийх гэтэл жин хүрдэггүй. 44 кг-аас илүү байж 48-д оролцох ёстой байдаг юм. Гэтэл би 44 кг хүрдэггүй. Тэгээд л баахан халуун цай, шингэн юм ууж байгаад орж байсан. Тэгээд спортын мастераа хийж байлаа. Хоёр өргөлтийн нийлбэр дүнгээр 115 өргөж байж спортын мастерын болзол хангадаг. Харин ОУХМ-ын болзол биелүүлэхэд 135 кг өргөх хэрэгтэй байдаг юм. Одоо бол би ОУХМ цолтой. Өнгөрсөн 2016 оны дөрөвдүгээр сард ОУХМ цолны болзлыг биелүүлсэн.

**-Улсын рекордыг маш олон удаа шинэчлэн тогтоож байгаа гэдэг утгаараа Б.Тунгалаг олон хүний анхаарлыг татаад байгаа. Хэзээнээс эхлээд улсын рекорд амжилтыг хэчнээн удаа эвдчихээд байна вэ?**

-Хамгийн анх хоёр жилийн өмнө өсвөрийн улсын аварга шалгаруулах тэмцээн Багануур дүүрэгт болоход огцом өргөлтөөр өсвөр үеийн рекордыг эвдэж байсан юм. Өмнөх амжилт нь 44 кг байсныг 48 болгож шинэчилж байлаа. Эхний оролтоороо 45 өргөөд, дараа нь 48 өргөсөн. Тэр үеэс эхлээд л улсын рекордыг бага багаар шинэчлээд яваад байсан. Гэтэл нэг мэдсэн чинь бараг 50 орчим удаа улсын рекордыг шинэчилчихэж.

**-Энэ жил улсын рекордыг бас эвдсэн. Өөрийнхөө рекордыг ахиулсан байх нь уу?**

-Биөнгөрсөнарванхоёрдугаар сард дөрвөн жил эвдэгдээгүй байсан рекордыг эвдсэн. Түлхэлттэй өргөлтөөр 77 өргөсөн дээд амжилт байсныг би 85 болгож шинэчилсэн. Харин сая улсын аварга шалгаруулах тэмцээнээр өөрийнхөө амжилтыг ахиулж, 90 кг өргөж чадсан.

**-Өөрийнхөө амжилтыг үе үе шинэчилж, ахиулж байгааг чинь юутай холбон тайлбарлаж болох вэ. Шургуу бэлтгэлийн үр дүн үү. Эсвэл жил ирэх тусам илүү техниктэй өргөж чадаад байн уу?**

-Хүндийн өргөлтийн спортод бярнаас илүү техник чухал. Энэ их баяртай хүүхэд учраас хүндийн өргөлтөөр хичээлүүлье гэсэн юм байхгүй. Өргөлтийн техникүүдийг маш сайн сурч байж өөрийгөө бэртээхгүйгээр хүнд зүйлийг өргөж чадна. Би арванхоёрдугаар сард 85 кг өргөж байсан. Сая таван кг-аар ахиулсан болохоор хүмүүс ямар мундаг юм бэ гээд байгаа юм. Би арванхоёрдугаар сард ч 90 кг өргөх боломжтой байсан. Гэхдээ жаахан алдаа гаргаад алдчихсан. Бараг л өргөчихсөн байсан ч барьж чадаагүй алдсан. Тухайн үедээ 90 кг-ыг заавал түлхэнэ гэж бодож байгаад сая санасандаа хүрлээ.

> ...Хоёр өргөлтийн нийлбэр 170 болчихвол ямар нэг тэмцээнээс хүрэл медаль ч болов авах боломжтой болно. Одоо би өөрийнхөө үеийн хүүхэд, залуучуудтай өрсөлдөх юм бол Олон улсаас медаль авна гэж боддог. 80 хавьцаа огцомдоод, 100 кг түлхчихвэл тэгээд л ямар ч медаль авах боломж бий...

**-Огцом өргөлтөөр ямархуу амжилт үзүүлж байна?**

-Огцом өргөлтийн рекорд нь 60 кг байсан. Өнгөрсөн арванхоёрдугаар сард би 70 кг болгож шинэчилсэн. Сая улсын аваргаар огцом өргөлтөө жаахан муу хийсэн. 65 кг л өргөсөн. Уг нь 71 кг-ыг захиалсан ч алдчихсан. Гэхдээ дараагийн тэмцээн дээр би 71 кг өргөж, рекорд хийнэ ээ. Энэ удаад жаахан муу өргөчихлөө. Хэрвээ өргөж чадсан бол нийлбэр дүнгээр 160 гаруй кг-ыг өргөж болохоор байсан.

**-Эхний оролтдоо 65 кг-ыг захиалчихаад, дараа нь шууд таван кг-аар нэмж болдог юм уу. Хүндийн өргөлтийн тамирчид чинь ганц хоёр кг-аар нэмээд байх шиг харагддаг шүү дээ?**

-71 кг гэдэг чинь миний өргөж чадах жин байсан учраас захиалсан. Хааяа өмнөх өргөлтөөсөө 7-8 кг-аар нэмээд л орчихдог шүү дээ. Хэрвээ өргөж чадахаар байвал дараагийн өргөлтдөө хэчнээн кг-аар ч нэмж болно.

**-Дараа дараачийн тэмцээний талаар ярианч. Ямар тэмцээнд оролцохоор төлөвлөж байна?**

-Улсын аварга шалгаруулах тэмцээнээр энэ жилийн тэмцээнүүд эхэлж байгаа юм. Ирэх гуравдугаар сард залуучуудын улсын аварга шалгаруулах тэмцээн болно. Би энэ жилээс өсвөрийн тэмцээнд оролцохоо больж байгаа шүү дээ. Нас хэтэрсэн. Тийм болохоор залуучууд, насанд хүрэгчдийн тэмцээндээ ороод явна. Залуучуудын аваргаар огцом өргөлтөөр өөрийнхөө амжилтыг шинэчлэхийг зорьж байна. 70-аас дээш кг-ыг өргөнө гээд хэлчихвэл өргөж чадахаа больчихдог юм болов уу, ядаг юм бол. Гэхдээ би хичээнэ ээ. Гуравдугаар сараас өмнө бэлтгэлээ сайн хийж чадвал 71-ээс дээшээ ч өргөж болно. Би долоо хоногийн зургаан өдөр бэлтгэл хийдэг. Бэлтгэлээ сайн хийвэл илүү амжилтад хүрэх боломж байгаа.

**-Чиний хувьд 48 кг-ын жинд Монголдоо л босоо байгаа. Харин дэлхийн аваргаас медаль авах хэмжээнд өргөнө гэвэл хэдэн кг-ыг өргөж байж амжилтад хүрэх боломжтой юм бол?**

-Хоёр өргөлтийн нийлбэр 170 болчихвол ямар нэг тэмцээнээс хүрэл медаль ч болов авах боломжтой болно. Одоо би өөрийнхөө үеийн хүүхэд, залуучуудтай өрсөлдөх юм бол Олон улсаас медаль авна гэж боддог. 80 хавьцаа огцомдоод, 100 кг түлхчихвэл тэгээд л ямар ч медаль авах боломж бий. Гэхдээ өргөх боломжтой, ойрхонсонсогдожбайгаачгэсэн яг өргөхөд нэг хэл нэмэгдэхэд л хэцүү байдаг. Яг тэмцээний үед ганц хоёр хэл нэмэгдэхэд мэдрэгдэхгүй ч гэсэн ахих хугацаа нь удаан байдаг. Би 90 кг өргөдөг байлаа гэж бодоход түүнээсээ буурахгүй барих хугацаа хэрэгтэй болно. 90 кг-аа дандаа өргөдөг болъё гэвэл бэлтгэл сургуулиалтаа сайн хийх хэрэгтэй. Би сая нэг удаа ороод л 90 кг-ыг өргөчихөж байгаа байхгүй юу. Тэгвэл 90 кг-ын штангаа хэзээ ч өргөсөн өргөж чаддаг болчихвол цааш нь ахиулна шүү дээ. Гэхдээ энэ жингээ барьдаг болохын тулд бэлтгэл сургуулилт хэрэгтэй л дээ.

**-Тэмцээн дээр өргөх нэг өөр. Харин бэлтгэл дээр тамирчид тэмцээнээсээ хамаагүй илүүг өргөж байсан тохиолдол байдаг талаар ярьдаг. Чиний хувьд бэлтгэл дээр хамгийн дээд тал нь хэдэн кг өргөж байв?**

-Би ерөнхийдөө л улсын аваргаар өргөсөн шигээ л өргөдөг. Сая түлхэлттэй өргөлтдөө өөрийнхөө хувьд сайн өргөсөн гэж бодоод байгаа. Харин огцом өргөлтдөө л жаахан муу орчихлоо. Үүнээс илүүг өргөж болохоор байсан юм.

**-Олон улсын тэмцээнд оролцож, гадагшаа явж байв уу?**

-Гадаад руу явж, олон улсын тэмцээнд оролцож байгаагүй. Харин Монголд өнгөрсөн жил “Тэмүүлэл” нэртэй олон улсын тэмцээн болсон. Тэр тэмцээнд оролцож жиндээ түрүүлсэн. Түүнээс өөрөөр гадагшаа явж тэмцээнд оролцоогүй л байна. Одоо надад тив, дэлхийн чанартай тэмцээнд оролцох боломж, бололцоо бүрэн бий. Хамгийн гол нь зардал мөнгөний асуудлаас болоод тэмцээнд явж чаддаггүй. Уг нь Олон улсын тэмцээний хуваарь гарчихсан байдаг. Би сайт руу нь ороод, 48 кг-ыг хардаг. Миний хувьд очиж оролцоод, медаль хүртчих боломжтой тэмцээнүүд байсан. Явдаг байж дээ гэж бодоод л өнгөрдөг. Энэ жилийн хувьд явах бодол их бий. Гэхдээ багш маань л аль тэмцээнд явахыг мэднэ. Дээрээс нь зардал мөнгөний асуудал шийдэгдэх үү, үгүй юу гээд асуудал их байна шүү дээ.

**-Манай тамирчид аль нэг компанийн ивээн тэтгэлгээр гадагшаа тэмцээнд явах нь бий. Чамд тийм боломж байж болно шүү дээ?**

-Уг нь тийм. Тамирчдыг дэмжээд л байгаа харагддаг. Харин намайг дэмждэг, тусалдаг газар гэж байхгүй. Аав, ээжээсээ л мөнгө аваад л тэмцээн, уралдаанд оролцдог. Би зүгээр суугаагүй ээ. Нэлээд хэдэн компани, аж ахуйн нэгжийн захиралуудтай уулзаж үзэж байсан. Дэмжиж, тусалъя гэдэг. Гэтэл яг тэмцээн уралдаанд явах дээрээ тулахад болохгүй байна, хямралтай байгаа болохоор боломж алга гээд дэмждэггүй. Олонх газар тэгдэг. Дээрээс нь манай хүндийн өргөлтийн спортыг дэмжих тал дээр муу. Чөлөөт, жүдогийн тамирчдыг бол сайн дэмжээд байх шиг байдаг. Гэхдээ сүүлийн үед арай гайгүй болоод байна. Сая М.Анхцэцэг эгч Олимпийн наадамд амжилттай оролцоод ирсэн. Түүний амжилтыг хараад дэмжиж болохоор юм байна гэж зарим нь харсан байх. Тэгээд хүндийн өргөлтийн тамирчдад хандах хандлага арай гайгүй л болоод байна.

**-Токио-2020 Олимпийн наадмын цикл эхэллээ. Токиогийн олимпийн наадамд оролцох зорилготой байгаа байх?**

-Ерөөсөө л миний зорилго Токиогийн Олимпийн наадамд оролцох. Тэгэхийн тулд өмнө нь олон тэмцээнд оролцож, эрх авах шаардлагатай болно. Тэр бүх тэмцээнд боломж л олдвол явна гэж төлөвлөж байгаа. Хүндийн өргөлтийн спортод дэлхийн аваргаас медаль авбал Олимпийн эрхээ шууд авдаг. Мөн Олимпийн эрх олгох тэмцээнүүд энд тэнд болно. Тэр тэмцээнүүдэд оролцож, эрхээ аваад, Токиогийн Олимпийн наадамд заавал оролцоно гэж бодож байгаа.

**-Одоо бол чи нийлбэр дүнгээр 155 кг өргөж байна. Гэтэл дэлхийн хэмжээнд өрсөлдөхийн тулд ядахдаа л 170-аас дээш, цаашлаад 200 руу дөхөж өргөх хэрэгтэй болох байх. Тэр амжилтад хүрэхэд юу дутаж байна?**

-Надад бэлтгэл дутаад байгаа гэж хэлэхгүй. Яагаад гэвэл би өөрийнхөө хэмжээнд биеэ дайчлаад, өдөр болгон бэлтгэлээ хийж байгаа. Харин намайг ивээн тэтгээд, манай багийг харж хандах хүн л хэрэгтэй байна. Мөн уураг, витамины тал дээр дэмжиж өгөх хүн хэрэгтэй байгаа юм. Энэ бүхнийг шийдээд, олон тэмцээнд оролцвол амжилт өснө. Тэмцээнд оролцоно гэдэг, ялангуяа дэлхийн хэмжээний тамирчидтай өрсөлдөнө гэдэг чинь өөрийгөө улам зоригжуулж, эрч хүч авах талбар шүү дээ. Тийм учраас олон улсын тэмцээн болгонд л оролцмоор байна.

**-Сүүлийн асуултыг өөрт чинь үлдээе?**

-Танай сониноор дамжуулаад аав, ээждээ, багшдаа, хамт олондоо, надад үргэлж тусалж байдаг Багануур дүүргийн ах, эгч нар, төрөлжсөн сургалттай Биеийн тамир, спортын дунд сургууль, “Аврагч” спорт хорооны бүх хамт олондоо баярлаж явдгаа хэлмээр байна.

NO STRESS

# ХАКҮХО 2017 ОНД 1047 ДАХЬ ДАВААГАА АВНА



Б.ДАВАА

Мэргэжлийн сүмогийн их аварга Хакүхо 2017 оны бэлтгэлээ эхэллээ. Шинэ жилийн амралтаа Гуамд өнгөрөөсөн Хакүхо 3-наас Миягино дэвжээнд шинэ оны анхны бэлтгэлээ хийсэн байна. Бэлтгэлийг спортын сэтгүүлчид үзэж сонирхон, 2017 онд тавьсан зорилгыг нь асуужээ. Хакүхогийн хувьд одоогийн байдлаар 1008 даваатай. Түүний хувьд мэргэжлийн сүмод хамгийн олон ялалт байгуулсан Кайогийн рекордтой зэрэгцэхэд 39 даваа хэрэгтэй. Өөрөөр хэлбэл, 40 давсан байхад л Хакүхо түүхэнд бичигдэх юм. Нэг башё 15 барилдаантай гэвэл хамгийн хурдандаа гэхэд нацүбашёд шинэ рекорд тогтоох боломжтой. Өнгөрсөн 2016 онд хоёрхон түрүүлж, нэг тэмцээн бүтэн өнжсөн гэсэн ёкозүна болсноосоо хойш хамгийн базаахгүй амжилттай дуусгасан. Харин энэ жилийн түүний зорилго 1047 дахь даваагаа авч түүхэнд бичигдэх ажээ. Тэгвэл бэлтгэлээ эхэлсэн Хакүхо шинэ зорилгынхоо тухайд “Цаг хугацааны л асуудал. Бие сэтгэлээ бэлтгэж байна” гэж ярьсан байна. Тайхо аваргын амжилтыг эвдэж, 2015 оны эхний башёд 33 дахь даваагаа авсныхаа дараа тэрбээр “Цаашдаа зорилгоо хэлж мэдэхгүй байна” гэж ярьж байжээ. Зорилго байхад улам хүчирхэгжинэ гэдэг. Тэгвэл 2017 оны түүний хамгийн том зорилго нь Кайогийн тогтоосон рекордыг шинэчлэх.

## Хакүхо Д.Даваажаргал: Ялалт бол нэр хүнд биш

**-Өнгөрсөн башёд аль эртнээс 1000 дахь даваагаа авах зорилго тавьсан байсан. Түүндээ ч хүрсэн. Ер нь сүүлийн хэдэн жилд рекордуудыг шинэчлэн тогтоож байгаа. Өмнөх башёд шинэ зорилго тавиад, хаана хүртэл явахаа хүртэл судалсан байсан байх?**

-Тайхо Коки аваргын дээд рекорд 32 дахь түрүүя авсны дараа, цаашдаа хаана хүрэх ёстойгоо судалсан. 2015 оны эхний башён 15 хоногийн хугацаа тун хүндхэн байж билээ. Түүний дараа, “1000 дахь даваагаа авна” гэж өөрийгөө урамшуулж байсан. Үүнийг рекорд эвдэж чадсан хүн л ойлгох байх.

**-Их аварга ихэнхдээ ялалт байгуулж, хэд хэдэн удаа рекорд тогтоосон. Гэсэн ч юунд ингэж санаа зовниж явдаг юм бэ. Бас яагаад?**

-Их аваргын болзол хангах үед Ёкозүнагийн тусгай зөвшөөрөл гэсэн бичгийг авсан. Түүнд “Нэр хүн, ур чадвараараа шалгарсан их аваргад олгоно” гэж бичсэн байдаг. Өмнө нь “Нэр хүнд” гэдгийг ялалт гэж л ойлгодог байсан. Тэр үед “ялалт бол нэр хүнд гэж боддог байлаа. Ямар ч нэр хүндтэй аварга байсан бай, үр дүн гаргаж чадахгүй бол зодог тайлна. Үүнээс үзэхэд, “Ялалт бол нэр хүнд биш”. Мэдээж, хэн ч ялалт байгуулж чадна. Ялалт гэдэг амархан зүйл биш. Гэхдээ олс ч гэсэн өөр өөр хэмжээстэй шүү дээ. Эдогийн үед хүртэл тооцоход, 200 гаруй жилийн Японы мэргэжлийн сүмогийн түүхэнд ердөө 71 ёкозүна л бий.

МЭДЭЭЛЭЛ

## Харүмафүжиг “Оны шилдэг сүмоч”-оор шалгаруулжээ

Японы спортын “Хочи Шимбүн” сониноос 2016 оны шилдэг сүмо бөхийг тодруулжээ. Ингэхдээ Харүмафүжи Д.Бямбадоржийг “Оны шилдэг сүмоч”-оор шалгаруулсан байна. Шалгаруулалтын эцсийн шатанд түүнээс гадна озэки Кисэносато, их аварга Хакүхо гэсэн гурван бөх үлдсэн гэнэ. Мэргэжлийн сүмод 1008 дахь даваагаа авсан Хакүхо 2016 онд хамгийн олон давсан Кисэносато нарыг Харүмафүжи давсан зэрэг амжилтыг нь үнэлж, энэхүү шагналыг олгохоор болжээ. Сонины зөвлөлөөс мэдээлснээр “Бүтэн нэг жилийн турш өөгүй сайхан барилдсан. Гурван аваргаас ганцаараа бүх тэмцээнд оролцсон” гэж тайлбарласан юм. Баярт мэдээг сонссон Харүмофүжи “Бүх хүч чадлаараа хичээн барилдсаны ач гарлаа. 2016 он том гэмтэлгүй өнгөрсөн. Баяртай байна” гэж сэтгэгдлээ илэрхийлсэн байна. Шагналыг энэ сарын 8-нд хацү башё эхлэх үед гардуулах гэнэ.

Улаанбаатарт:

Маргааш
Өдөр -12
Шөнө -21

Нөгөөдөр
Өдөр -18
Шөнө -22

Өдрийн зурхай



**ӨВЛИЙН ДУНД ЦАГААН ХУЛГАНА САРЫН ТАВАН ШАР МЭНГЭТЭЙ ХАРАГЧИН МОГОЙ ӨДӨР**

**Үс засуулбал:** **Нас уртасна**

**Наран ургах, шингэх:** **08.37-17.16**

Тухайн өдөр үхэр, тахиа жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба бар, туулай жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр хууль цааз гаргах, батлах, хэрэглэх, хулгай дээрмийг номхотгох, гэмтнийг шийтгэх, мал адгуус номхруулах, сүм дуганыг сэргээх, газар лусын зан үйл хийх, өр барагдуулах, буг дарах, газрын ам бооход сайн. Ургаа мод таслах, газрын ам нээх, гөлөг тэжээх, байшингийн суурь тавих, угаал үйлдэхэд муу. Өдрийн сайн цаг нь үхэр, луу, морь, хонь, нохой, гахай болой. Хол газар явaар одогсод баруун зүгт мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулбал нас уртадна.

МЭДЭЭЛЭЛ

## Хацү башёд Монголоос есөн бөх зодоглоно

Японы сүмо бөхийн холбооноос ирэх сарын 8-нд Токиод эхлэх Хацү башё буюу нэгдүгээр сарын тэмцээний банцүкэг өнгөрсөн сард зарласан байна. Тус башёд Монголоос есөн бөх зодоглох бөгөөд тэднээс Тамаваши Мөнх-Оргил зүүний сэкивакэд жагссан нь сүмогийн түүхэнд гадаад бөхчүүдээс хамгийн удаан хугацааны дараа сэкивакэ болсон бөх болж байгаа.

| **Зүүн** | **Цол** | **Баруун** |
|---|---|---|
| Какүрюү | Ёкозүна | Харүмафүжи |
| Хакүхо | Ёкозүна | |
| Кисэносато | Озэки | Гоэйдо |
| Тэрүнофүжи | Озэки | Котошёогикү |
| Тамаваши | Сэкивакэ | Шёодай |
| Такаясү | Комүсүби | Точиношин |
| Такарафүжи | Маэгашира 1 | Митакэүми |
| Шёохозан | Маэгашира 2 | Араваши |
| Окиноүми | Маэгашира 3 | Икиой |
| Точиоозан | Маэгашира 4 | Эндо |
| Такэказэ | Маэгашира 5 | Ёшиказэ |
| Чиёшёома | Маэгашира 6 | Котоюүки |
| Миёогирюү | Маэгашира 7 | Аойяма |
| Хокүтофүжи | Маэгашира 8 | Чиёнокүни |
| Кайсэй | Маэгашира 9 | Ишиүра |
| Таканоива | Маэгашира 10 | Соококүрай |
| Кагаяки | Маэгашира 11 | Нишикиги |
| Такакэйшёо | Маэгашира 12 | Дайшёомарү |
| Гагамарү | Маэгашира 13 | Ичиножёо |
| Чиёотори | Маэгашира 14 | Чиётайрюү |
| Чиёо | Маэгашира 15 | Саданоүми |
| Оосүнараши | Маэгашира 16 | |

**Жюүрёо**
Зүүний 2 Кёкүшюүхо Т.Эрдэнэбаатар
З-4 Сэйро А.Өнөболд
Б-4 Азүмарюү С.Тодбилэг

**Макүшита**
Б-1 Асасэкирюү Б.Дашням
З-4 Дайшёохо Р.Шижирбаяр
З-7 Шёотэнро Д.Нямсүрэн
З-16 Сакигакэ Я.Баттүшиг
Б-16 Гочёозан Д.Ууганбаатар
Б-17 Кагамио Б.Нанжид
З-20 Кирибаяма Б.Лхагвасүрэн
Б-21 Рюүонами Б.Буянжаргал
Б-46 Такакасүга Э.Энхманлай
З-51 Асахирюү Б.Дэнзэнсамбуу

**Санданмэ**
Б-59 Садахикари Д.Наранцогт

TENGIS MOVIE THEATRE




Аз жаргал, зовлон гуниг, хайр дурлал, хардалт, амжилт, бүтэлгүйтэл гээд л хар, цагаан хосолж байдаг хүний амьдралд бид төрөхдөө "Амьдралын сурах бичиг"-ээ өвөртлөөд ирдэг бол хэчнээн сайхан! Өөрийн биеэр туулж байж л амьдралын зах зухаас мэдэж, сурч, туршлагажиж ухаардаг. Энэ бол "Амьдралоги" юм. Тэгвэл амьдралынхаа 2 дахь үеийн хямралд орсон гэр бүлийн хос, амжилттай яваа ч заяаны ханиа хараахан олоогүй бүсгүй, залуу халуун насныхаа алдаа, оноог дэнслүүлэн яваа оюутан охин болон киноны бусад дүрүүдийн аз жаргалын төлөөх тэмцэл болон тэдний санаанд оромгүй сонголтуудыг "Амьдралоги" романтик инээдмийн уран сайхны киноноос үзээрэй.



Assassin's Creed буюу Алуурчны үнэмшил видео тоглоомоос сэдэвлэн бүтээв.



Жазз хөгжимчин Сибастиан жүжигчин болох хүсэл мөрөөдөлтэй Миа бүсгүйд дурлана. Миа киноны шалгаруулалтуудад орохын хажуугаар кино одуудад кофе зөөдөг бол жазз хөгжимчин Сибастиан ядруухан баранд коктэйлний үдэшлэгийн хөгжим тоглож амь зогоодог байв. Амжилтад ойртохын хэрээр тэд тэдний эмзэгхэн хайрыг сэвтээх хүнд шийдвэрүүдийг гаргах хэрэгтэй болно.